

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +15  
Шөнө +7

**УЛС ТӨР**

БОАЖ-ЫН САЙД Д.ОЮУНХОРОЛ  
12 ХҮҮХДЭД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ СУРАХ  
ЭРХИЙН БИЧИГ ГАРДУУЛЛАА

II нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

ТЭНЭГЛЭЖ БАС ТЭСЭРЧ  
ЧАЦДАГ У.ХҮРЭЛСҮХ


V нүүрт

Дугаарын **60** мөр  
Бичин жилийн  
өвөлд бэлэн үү

Н.ПУНЦАГБОЛД

ҮЗЭЛ БОДОЛ

## БАНКУУД ДАМПУУРАХ БУС ДААМ ГАРЧИХААД БАЙНА



Б.ӨНӨРТӨГТОХ

Зуны халуун өдрүүд өндөрлөж, амралт зугаалгын сар ч дуусч байна. Хэдхэн хоногийн дараа сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жил эхэлж, Улаанбаатар хот оюутнуудын хөлд дарагдана. Өчигдрөөс цэцэрлэгийн бүртгэл эхэлж, эцэг, эхчүүд д аанай л дугаарлаж байгаа. Гэхдээ энэ жил ч гэсэн бид хүүхдийнхээ азанд найдаад, цэцэрлэгтэй болохоо хүлээх болчихоод байна. Энэ мэтээр жаахан бужигнаж, хурим найр гэж явтал аравдугаар сартай золгож, халаалт дулаан сануулж эхэлнэ дээ. Ингэхэд бид өвөлд бэлэн үү. Яах вэ, хот суурингийнхэн халаалт дулаанаа яаж ийгээд авчих байх. Шугам сүлжээний засвар үйлчилгээ хийгдэх ёстой хугацаандаа хийгдэж л байгаа. Тийм болохоор тэр тал дээр санаа зовоод яах вэ. Харин бичин жилийн өвөл хатуу болно гэж байгаа энэ үед хэдэн малаа хиаруулчихгүй аваад гарах бэлтгэлээ л бид сайн хийх хэрэгтэй байна.

Монголчууд ууртай бас хямралтай байна. Налгар зуны гурван сарыг амарч, зугаалж, найрлаж өнгөрөөдөг монгол түмэн өнөө жил тийм байж чадсангүй. Улс орныхоо хувь заяаг даатгасан улс төрийн нам нь мэргэжлийн бус мөнгөний томилгоог зунжин хийж итгэсэн сэтгэл рүү нь ус цацаж бухимдууллаа. Улсын ажлыг удирдаж эхлээгүй байхдаа л улс орноо дампуурсныг дэлхий дахинд зарлаж, Монголын нэр хүндийг шороотой хутгаж орхисон. Ядахад яр гэгчээр бөмбөрцгийн ард түмний эв нэгдлийн хэмээгдэх олимпын наадамд оролцсон монгол тамирчид маань жижиг орны зовлонг хангалттай эдэлж гурван ч медалина луйвардуулсан нь амар амгалан зуныг өнгөрүүлэх аргагүйд хүргэсэн гэх. Тив дэлхийд Монгол Улсын нэрийг гаргаж байгаа тамирчдаа ч бодохгүйгээр бид үгээгүй ядуу, гуйлгачин улс боллоо хэмээн зарлаж орхисноороо мөнгөнд дурласан шүүгч нарын өгөөш болж хувирсан. Олон улсын хэвлэлээр монголчууд олимпын тамирчдынхаа мөнгийг өгч чадахгүй болтлоо эдийн засаг нь доройтож, ядуурсан гэх мэдээлэл ар араасаа гарч

эхэллээ. Энэ лав сайны тэмдэг биш. Монголбанкны валютын нөөц дуусч буйг Төв банкны Ерөнхийлөгч нь олонд зарлаж дуулиан дэгдээв. Араас нь Сангийн сайд нь цалингаа тавьж

чадахгүйд хүрснээ зарлаж, Ерөнхий сайд нь цалин хасах тухай мэдэгдэл хийхээс өөр муу зүйл хаана байх билээ. Хамгийн сүүлийн мэдээгээр Олон улсын санхүүгийн үнэлгээний

Standard&Poor's agency Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулж В-ээс хасах В болголоо.

Үргэлжлэл нь III нүүрт

Би МОНГОЛОО  
ингэж хөгжүүлнэ

### Д.БАТСАЙХАН:

Хөгжье гэвэл өөрчил гэсэн үг  
байдаг шүү дээ

Э.ТУУЛ

Монгол Улсын Ерөнхий сайд 2016 оны наймдугаар сарын 09-ний өдрийн захирамжаар Завхан аймгийн Засаг даргаар Д.Батсайханыг томилсон билээ. Тэрбээр "Хаан" банк, "Төрийн банк"-ны захирал, Завхан аймгийн Ардчилсан намын даргаар ажиллаж байсан туршлагатай нэгэн билээ. Д.Батсайхан ажлаа хүлээж авах үедээ "Төрийн тамгыг хүндэтгэлтэйгээр хүлээлгэн өгч байгаа Ж.Жамъян тив танд талархал илэрхийлье. Таны эхлүүлсэн, өрнүүлсэн сайн үйл бүхнийг хичээнгүйлэн үргэлжлүүлэх болно. Ирж буй цаг хугацаа эдийн засгийн хувьд хүндхэн байх ч бэрхшээл гэж харалгүйгээр, гарц хайн ухаан бодлоо уралдуулан хичээж ажиллах болно" хэмээж байсан юм. Ингээд энэ удаагийн "Би Монголоо ингэж хөгжүүлнэ" булангийнхаа зочноор Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайханыг урьж, ярилцсанаа хүргэе.



-Юуны өмнө Завхан аймгийн Засаг даргаар томилогдсон танд баяр хүргэе. Завханд зуншлага хэр болов доо?  
-Маш их баярлалаа. Завхан аймгийнхаа Засаг даргын ажлыг хүлээж аваад долоо хонож байна. Манай аймагт зуншлага их сайхан, энэ жилийн хувьд

онцгой сайхан боллоо. Одоо бид өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангахад анхаарал хандуулж байна. Ерөнхийдөө өвөлжилтийн бэлтгэл ажлыг маш сайн хангах нь чухал. Түүнчлэн энэ өвөл бас эрт хүйтрэх төлөвтэй байгаа тул өвлийнхөө бэлтгэлийг хангах, өвс тэжээлээ базаах, хадлангаа авах гээд ажил их бий. Орон нутгийн бэлтгэлээс гадна суурин газрын өвөлжилтийн бэлтгэл гэдэг бас их чухал асуудал. Энэ хүрээнд тулгамдаж байгаа гурван үндсэн асуудал бий. Хамгийн түрүүнд замын асуудал байна.

Үргэлжлэл нь IV нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## СУГАЛААНД ОДГУЙ ХОЁР НАСТНУУД ХООСОН ХОЦРОХ НЬ

Н.БАТЗАЯА  
Ц.СОЛОНГО

Шинэ ногооны үнэр хаа нэгтгээ дэлгүүрийн лангуунаас ханхийж, гүйцэд боловсорсон шинэхэн жимс нүд булаах нь намрын эхэн сар аль хэдийн гарсныг илтгэх шиг. Байгаль дэлхийн шинэ бүхэнтэй зэрэгцээд хүүхэд багачууд ч шинэ бүхэнтэй танилцан хорвоогийн утга

учрыг танин мэдэж, нийгмийн харилцаанд орж, бие хүн болон төлөвшихөд бэлдээд их хотын амьдрал тун завгүй үргэлжилж байна. Тэр дундаа цэцэрлэгийн багачуудын бие хүн болон төлөвших, сургуулийн өмнөх боловсролыг улсын цэцэрлэгт үнэ төлбөргүй эзэмшиж чадах эсэх нь энэ тавхан хоногт шийдэгддээ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын өгсөн албан даалгаврын дагуу энэ сарын 22-ны 08:00 цагт

цэцэрлэгийн бүртгэл албан ёсоор эхлээд буй. Цэцэрлэгийн бүртгэл эхлээд гурав хонож байгаа ч эцэг, эхчүүд өдөр шөнөгүй дугаарлаж, бүр зарим цэцэрлэгийн орчимд эмх замбараагүй байдал үүсэхэд хүрчээ. Тиймээс манай сурвалжлах хэсэг хоёр өдрийн турш цэцэрлэгийн бүртгэл хэрхэн явагдаж байгаа талаар сурвалжиллаа.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

# ХУРИМЫН БЭЭЛЭГ

## БҮХ ЧИГЛЭЛД

50%  
OFF

# ШИНЭХЭН ХОСУУДАЛД

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2250.00	2273.00	ФУНТ	2911.00	3011.00	АМ.ДОЛЛАР	2252.00	2278.00
ЕВРО	2526.00	2593.00	РУБЛЬ	32.70	37.00	ЕВРО	2520.00	2617.00
ИЕН	22.24	22.86	ЮАНЬ	336.00	345.90	ИЕН	22.15	23.10
						ФУНТ	2926.00	3038.00
						РУБЛЬ	33.71	37.04
						ЮАНЬ	338.30	345.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## БОАЖ-ЫН САЙД Д.ОЮУНХОРОЛ

# 12 ХҮҮХДЭД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ СУРАХ ЭРХИЙН БИЧИГ ГАРДУУЛЛАА

Ж.ОТГОН

УИХ-ын гишүүн, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол өчигдөр Баянзүрх дүүргийн иргэд, сонгогчидтойгоо анхны уулзалтаа хийлээ. Уг уулзалтад тус дүүргийн 1-3, 7, 21, 27 дугаар хорооны иргэд оролцлоо. Тэрбээр уулзалтыг нээж хэлсэн үгэндээ “Ажил амьдралынхаа 25 жилийн холбосон Баянзүрх дүүрэгтэй нэр дэвшиж, та бүхнийхээ дэмжлэгтэйгээр УИХ-ын гишүүнээр дөрөв дэх удаагаа сонгогдлоо. Надад итгэж дэмжсэн та бүхэндээ чи сэтгэлийн халуун талархал илэрхийлэе. Миний бие салбарынхаа нөхцөл байдалтай танилцаад ажлаа эхэллээ. Өмнө нь ажиллаж байхдаа эхлүүлсэн олон ажлуудаа үргэлжлүүлэн хийнэ. Шинэ Засгийн газар нийгэм эдийн засгийн амаргүй нөхцөл байдалтай танилцаад ажлаа эхэлж байна. Бидэнд эдийн засгийг тогтворжуулах, төгрөгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх, ард иргэдэд ажлын байраар хангаж, орлоготой болгох, хувийн хэвшлийн бизнесийг дэмжих, томоохон төслүүдийг хөдөлгөж, эдийн засгийн эргэлтэд оруулахын зэрэгцээ байгалиа хамгаалах, байгалийн нөөц хаягдалгүй ашиглах шаардлага тулгарч байна” гэлээ.

Хэдийгээр эдийн засгийн байдал хүнд байгаа ч Засгийн газар ирээдүйгээ өөдрөгөөр харж, хямралаас гарах цогц төлөвлөгөө боловсруулаж байгаагаа энэ үеэр дуулгаж байлаа. Энэ үеэр сүүлийн үед нийгэмд хамгийн их хүлээлт үүсгээд байгаа зарим асуултад иргэд хариулт авсан юм. Энэ хүрээнд хүүхдийн мөнгө болоод ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгоно гэдгийг иргэд таатай хүлээн авч байв. Өнөөдөр нэн ялангуяа



Улаанбаатар хотын гэр хороолол хөрс, ус, агаарын бохирдол маш том асуудал болоод байгаа. Тиймээс ч орон сууцжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр ажиллаж байгаа гэдгээ сайд дуулгасан. Түүнчлэн тэрбээр “Бүх асуудлын нэгмөсөн шийдэх хэрэгжүүлэх тэргүүн туршлага, шинэ дэвшилтэт технологийг ашиглахаар Азийн хөгжлийн банктай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Улаанбаатар хотын гэр хорооллын 8000 гаруй өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах жишиг төслийг хэрэгжүүлэх болно. Энэ ажилд БНХАУ тусламж үзүүлэхээр болоод байна. Түүнчлэн Мянганы сорилтын сан

мөн асуудлаа тавьсан. Тиймээс энэ ажлыг зөвхөн Улаанбаатар хотод төдийгүй орон нутагт ч туршиж, үзэхээр болоод байгаа. Энэ ажлыг хамгийн түрүүнд миний тойргийн 27, 21, 2 гэсэн гурван том хорооноос эхлүүлэх болно. Эхлээд туршаад үзье. Үнэхээр гэр хорооллын цэвэрлэх байгууламжийг доторлогоотой боловсон бие засах газартай, гэрэлтүүлэгтэй болгоод энэ ажлыг эхлүүлэхээр магадгүй орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр илүү ажил болох ч юм бил үү. Өөрөөр хэлбэл, дэд бүтцийн асуудлыг шийдээд өгчихвөл гэр хорооллын иргэд эрүүл, сайхан амьдрах нөхцөл боломж бүрдэх байх гэсэн бодлогоотойгоор энэ ажлыг эхлүүлэхээр хөөцөлдөж байна” гэдгийг дуулгасан юм.

Эмэгтэй гишүүнийхээ хувьд тэрбээр нийгмийн эмзэг асуудалд анхаарлаа хандуулахгүй үлдээснгүй. Учир нь хэдхэн хоногийн дараа хичээлийн шинэ жил эхэлж, хүүхэд багачууд хичээл сургуульдаа орох гэж

бие 12 хүүхдэд үнэ төлбөргүй сурах боломжийг олгож байна. Энэ боломжийг ашиглан сайн суралцаж, улс орондоо хэрэгтэй, мэдлэг чадвартай боловсон хүчин болоорой” хэмээн захилаа. Мөн энэ үеэр ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй хүүхдэд хичээлийн хэрэгсэл гардуулж өглөө. Түүнчлэн улс орныхоо хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулсан ахмадуудыг салбарын болон намын одон медалиар шагнаж урамшууллаа.

нь битгий хэл бүтэн дөрвөн жил нэг ч удаа сонгогчдынхоо царай хардаггүй УИХ-ын гишүүн зөндөө байдаг. Эмэгтэй хүний нарийн ухаан энэ төрд хэрэгтэй гэдгийг харуулах цөөхөн эмэгтэй гишүүдийн нэг гэдэгтэй маргах хүн цөөн биз. Тухайлбал, хэдхэн хоногийн дараа хичээл, сургууль эхлэх гэж байна. Тиймээс ч амьжиргааны төвшин доогуур айл өрхийн хүүхдүүд хичээлийн хэрэгсэл бэлэглэж, оюутнуудад үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгийг гардуулж байна. Хэрвээ эрэгтэй хүн байсан бол энэ нарийн зүйлийг мэдэхгүй. Төр засаг хямраад сүүлийн хэдэн сар хүүхдийн мөнгө ч өгөхгүй байна. Тиймээс ч орлого гээд байх зүйлгүй хүүхдийнхээ мөнгөөр сургуулийнх нь бэлтгэлийг базаадаг айл өрхүүд хэцүүдэж байгаа. Тиймээс 200 гаруй хүүхэд шинэ цүнхээ үүрээд сургуульдаа очно гэдэг бол маш том нэмэр болж буй хэрэг. Эдийн засгийн хямралаас болоод ажилгүй болж байгаа иргэд олон байна. Наймаа хийгээд ямар ч орлого орохгүй болчихлоо. Гэтэл сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл ямар үнэ өртөгтэй байгаа билээ. Ганцхан үзэг балны сав авлаа гэхэд л 5-8 мянган төгрөгийн өртөгтэй байх жишээтэй. Тиймээс хоногийн хоолоо яахаа мэдэхгүй байгаа хүмүүс хүүхдүүддээ хичээлийн хэрэгсэлийг нь бүрэн бэлтгээд сургуульд нь явуулна гэдэг чанга байна. Харин манай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн маань 200 гаруй хүүхдийн асуудлыг ингээд шийдээд өгч байгаад үнэхээр их баярлаж байна. Тиймээс цаашдаа ч олон сайн ажил хийж, ард иргэдийнхээ амьдралтай ойрхон байж, жаргал, зовлонг нь байнга сонсч байгаасай гэж хүсч байна.



**Х.Зават: 200 гаруй хүүхдийн асуудлыг шийдээд өгч байгаад үнэхээр их баярлаж байна**

*/Баянзүрх дүүргийн II хорооны иргэн/*

Д.Оюунхорол УИХ-ын гишүүн болчихоод удаагүй байхдаа иргэдтэйгээ эргэх болбоотой байж, анхныхаа уулзалтыг ийнхүү зохион байгуулж байгаад баяртай байна. Ингэж ойрхон уулзах

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Ульсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцанд эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Оюутны 70 мянга болоод автобусны хөнгөлөлтийг зогсооно

Төсөв санхүү хүндрэлтэй байгаа учир 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болоод байгаа билээ. Уг хуулийг дагалдан Нийгмийн даатгалын сангийн тухай, Хүний хөгжил сангийн тухай хуулиуд ч өөрчлөгдөх болоод байна. Тэгвэл Засгийн газраас өргөн мэдүүлсэн уг хуулийн төсөлд Монгол Улсын иргэн бүртэй холбоотой өөрчлөлтүүд орохоор болоод байна. Энэ оньг дуусалт бүсээ чангалах болсон онцлох өөрчлөлтүүдийн тухайд, Хүүхдийн хүүхдийн мөнгийг 1-10 дугаар бүлэгт хамрагдсан өрхийн 0-18 насны хүүхдүүд буюу нийт хүүхдийн 60 хувьд нь 20 мянган төгрөгийг үргэлжлүүлэх олгохоор тусгажээ. Харин үлдсэн 40 хувьд хамрагдах бусад хүүхдэд олгох мөнгийг төсвийн боломжтой уялдуулан хойшлуулах, 2019 оноос нөхөн олгохоор тооцож байгаа аж. Түүнчлэн УИХ-аас 2015 онд батлагдсан Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль тогтоомжийг 2016 онд хэрэгжүүлэхэд зориулж нийт 10.6 тэрбум төгрөгийн зардал батлагдсан билээ. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,263 хүүхэд харагч бүртгэгдэж, 6,175 хүүхэд уг үйлчилгээнд хамрагдсан ба төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр 746.1 сая 25 төгрөг зарцуулагдсан байна. Үүнийг харгалзан үзээд уг үйлчилгээнд батлагдсан зардлыг 4,906.2 сая төгрөгөөр

бууруулах боломжтой гэж үзэн зохих өөрчлөлтийг төсвийн тодотголд тусгахаар болсон байна. Цаашид хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг төсвийн боломжтой уялдуулан хойшлуулахаар болжээ. Мөн их дээд сургуульд суралцагч оюутны сурлагын амжилтад үндэслэн олгодог үндэсний тэтгэлэг 70,200 төгрөг олгохыг зогсоох асуудлыг төсвийн тодотголд оруулжээ. Түүнчлэн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч оюутны тэтгэлгийг төсвийн боломжтой уялдуулан түр зогсоох асуудлыг ч тусгасан байна.

Нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ ирж, буцахдаа зайлшгүй зорчих оюутны зорчих төлбөрийн хэмжээг 50 хувийг нь төр хариуцаж, бусад хэсгийг тухайн оюутан өөрөө хариуцдаг болох нь. Иргэдийн дургүйцлийг хамгийн их хүргэж буй асуудал нь төрийн жинхэнэ, төрийн тусгай болон багш, эмч зэрэг төрийн үйлчилгээний зарим албан хаагчдыг өндөр насны тэтгэвэрт гарахад нь ажилласан жилээс хамааран 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгодог. Энэхүү журамд өөрчлөлт оруулан 1-12 сарын цалингын дундаж хэмжээтэй тэнцэх тэтгэмжийг олгох тухай хуулийн төсөлд тусгасан байна. Энэ мэт бүсээ чангалах олон жагсаалтыг гаргаад байна.



**Дизель, цахилгаан хөдөлгүүртэй зүтгүүрийг туршиж байна**

“Сиймэнс” компани нь хосолмол хөдөлгүүртэй Чаржер загварын зүтгүүрийг АНУ-ын Колорадо мужийн Пуэбло хот дахь Тээврийн технологийн төвд туршиж эхэлжээ. Энэхүү шинэ үеийн зүтгүүр нь цагт 200 км хурдтай бөгөөд хорт утаа ялгаралтын дөрөвдүгээр төвшний стандартад нийцэх анхны зорчигч тээврийн зүтгүүр юм байна. Чаржер загварын зүтгүүр нь 4400 морины хүчин чадалтай “Cummins QSK95” дизель хөдөлгүүртэй бөгөөд хорт утааны ялгаруулалт нь 0 түвшний зүтгүүрээс дараг 90 хувь бага байгаа юм. “Сиймэнс компани”-ийн мэдэгдэж буйгаар туршилтаар хурдын дээд хэмжээг шалгах хэд хэдэн туршилтыг явуулахын сацуу зүтгүүрийн хурдлах болон тоормослох чадварыг мөн шалгах юм байна. Иллинойс, Калифорни, Вашингтон, Минчиган, Миссури болон Мэриланд мужуудын тээврийн газраас захиалга ирж байгаа нь энэхүү цахилгаан зүтгүүр ирэх жилүүдэд нийтлэг дүр төрх болохоор байна.

“Сиймэнс” компанийн Хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан Ерөнхийлөгч Майкл Кахил туршилтыг эхлүүлэх тухай хэвлэлээр ярихдаа “Эдгээр дизель, цахилгаан хөдөлгүүртэй зүтгүүрүүд нь АНУ-д цэвэр, үр ашигтай төмөр замын тээврийн шинэ үеийг төлөөлж байгаа бөгөөд Пуэбло хотод явуулж байгаа энэхүү туршилт нь бусад мужуудад төмөр замын дэвшилтэд технологийг түгээхэд чухал алхам юм. Сиймэнс Чаржер зүтгүүр нь АНУ-ын Байгаль орчин хамгаалах газрын хорт утаа ялгаралтын дөрөвдүгээр төвшний стандартад нийцсэн анхны дизель, цахилгаан хөдөлгүүр хослуулсан зүтгүүр байгаад зогсохгүй мөн Америкийн үйлдвэрлэгч нар юу бүтээж чадахыг харуулсан гайхалтай жишээ боллоо” гэжээ. Чаржер зүтгүүрийг мөн Флорида мужийн Брайтлайн хотын зорчигч тээвэрт ашиглах юм байна. Эхний ээлжийн зүтгүүрүүдийг энэ оны сүүлээр хүргэх бөгөөд зуны улирлаас эхлэн зорчигч тээвэрт ашиглаж эхлэх юм байна.

## Яамдын бүтэц ирэх сард бүтэн болох нь

Төрийн албаны зөвлөлөөс зарим яамдын төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилгодох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаад байгаа. “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилгодох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу Гадаад харилцааны, Хууль зүй, дотоод хэргийн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн, Эрүүл мэндийн яамдын Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилгодох ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд зарласан. Энэхүү зарын дагуу болзол хангасан хэн ч сонгон шалгаруулалтад орох эрхтэй бөгөөд ирэх есдүгээр сарын 09-ний өдрөөс өмнө материаллаа бүрдүүлж өгөх учиртай гэнэ. Харин шалгаруулалт есдүгээр

сарын 12-ны өдөр болно. Дээрх яамдын төрийн нарийн бичгийн даргын албан горниогчид эхнээсээ тодроод байгаа. Нэр бүхий яамдын сонгон шалгаруулалтад орох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилго эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байх ёстой юм.

## Аливаа тушаал, шийдвэр амьдралд бодитоор хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ гэв

Зам, тээврийн хөгжлийн яамны нийт албан хаагчид албан баримт бичгийн агуулга, бүтэц, хэв загварыг ижилтгэх, баримт бичигтэй ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгох, баримт бичгийн эмх цэцэг, хадгалалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор “Төрийн албан хэрэг хөтөлөлтийн үндсэн заавар” сургалтад хамрагдлаа. Энэхүү сургалтыг Зам, тээврийн хөгжлийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргаас

өгсөн үүргийн дагуу тус яамны Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ удирдан зохион байгуулсан бөгөөд албан хэрэг хөтөлөлт болон тушаал гаргахад анхаарах асуудлын хүрээнд мэдээлэл өгөв. Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд, оновчтой арга барилаар, түргэн шуурхай явуулахын тулд албан хэрэг хөтөлөлтийн асуудал нэн тэргүүнд тавигддаг. Тиймээс тухайн үйлчилгээг үзүүлэгч төрийн албан хаагч нарийн мэргэшсэн байх шаардлагатай

тул энэхүү сургалтыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай хэмээн үзэж байгаа юм.

Төрийн албан хэрэг хөтөлөлт стандартын дагуу явагдаж, боловсронгуй болсноор төрийн албаны тухай байгууллага болон албан тушаалтнаас гарч буй эрх зүйн аливаа акт, баримт бичиг нь амьдралд бодитоор бүрэн хэрэгжих үндэс суурь тавигдана гэдгийг сургалтад хамрагдсан албан хаагчид хэлж байлаа. Ингэснээр

үйлчлүүлэгчийн эрх ашиг, санаа бодолд нийцсэн шийдвэр гарах ач холбогдолтой аж. Сургалтын үеэр ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ “Төрийн аливаа ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх үйл явч нь тухайн нийгмийн тогтвортой хөгжил, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн хүрээний үйл ажиллагаа бөгөөд албан хаагчид та бүхэн тухайн салбарын уураг тархи юм” гэдгийг онцлож байлаа.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

# БАНКУУД ДАМПУУРАХ БУС ДААМ ГАРЧИХААД БАЙНА

## Бичин жилийн өвөлд бэлэн үү

Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Мөн эдийн засгийн өсөлтийн төлвийг ч бууруулжээ. Ингэснээр олон улсад итгэл хүлээдэг улс орны тооноос үндсэндээ хасагдаж байна. Улсынхаа нэр хүндээр бонд босгох байтугай, зээл авах боломж ч хаагдах магадлалтай. Эрх баригчдын хүсээд буй “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаа гэхэд гадныхан бидний юу хийхийг, ямар зүйлд зарцуулахыг тогтмол хянаж, улсын дотоод нууц гэж байхгүй болно. Мөнгө санхүүтэй холбоотой бүх зүйлд гадны хяналт орж ирнэ гэсэн үг. Тиймээс олимпын медаль луйвардуулсан олны бүхмидэл төд удахгүй улсаараа хямарсан, өр зээлд баригдсан, дампуурлаа зарлаж, зээлийн дарамтад орсон нийгмийн тэмцэл болон хувирч мэдэх нь. Нөгөө талаар өнөө жил монголын эдийн засагт, ард түмний амьдралд хамгийн том цохилтыг арилжааны банкууд өгөх нь тодорхой болж байна. Тодруулбал, арилжааны банкууд зээлээ хумих, хаах боломжийг Төв банкны захирлуудын зөвлөлд бүрдүүлж бодлогын хүүг 15 хувь болгосон нь өндийх аргагүй цохилт болов. Банкууд зах зээлд баталгаагүй, найдваргүй зээл гаргаж агаа үзэх үү, эсвэл Төв банкнд мөнгөө өндөр хүүтэй зээлдүүлж, хав дарчихаад суух уу гэдэг сонголтыг энэ өдрүүдэд хийх нь. Ингэснээр цалин, тэтгэврийн зээлийн хүү буурах бус өсч, ипотекийн зээл зогсонги байдалд орох нь тодорхой. Тэд хэзээ ч эрсдэлтэй алхам хийдэггүй. Тиймдээ ч өнгөрсөн гурван сард ар араасаа өрнөсөн эдийн засгийн энэ бүх шокийн мэдээлүүд ард түмний нуруунд хамгийн хүнд ачаа болж очих нь тодорхой болж байна. Банкууд зээлээ хумих бодлого хэрэгжиж эхэлснээр хөл дээрээ босох гэж чадан ядан зүтгэж буй олон зуун аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж дампуурна. 2015 оны сүүл, 2016 оны эхээр гэхэд л 2000 гаруй аж ахуйн нэгж, компани ямар шалтгаанаар гэдэг нь тодорхой бус байдалтайгаар үүд хаалгаа барьжээ.

Эдгээр компаниудын цаана хэдэн мянган хүний ажлын байр, амьдралын баталгаа яригдаж байсныг энд нурих нь илүүц биз. Бодлогын хүүг нэмэгдүүлсэн шийдвэрээ Төв банк арилжааны банкуудыг дампуурлаас аврахын тулд, үндэсний мөнгөн тэмдэгтээ хамгаалж, үнэ цэнэтэй болгохын тулд хэмээн тайлбарласан. Гэвч арилжааны банкууд өнөөдөр дампуурах гэхээс илүү харин ч даам гарчихаад байгааг нуух юун. Уул уурхайн хөрөнгө оруулалт багассан, улс орноороо бүлээ чангалсан өнгөрсөн өдрүүдэд хамгийн ашигтай ажиллаж чадсан нь банкууд. Шинэ баригдсан баршга болгоны буланд тэд салбараа нээж буй. Дэлгүүр, үйлчилгээний төв болгонд хэдэн сая төгрөгийн үнэтэй бэлэн мөнгөний машин жирийнх нь орж байрхацгааж байна, тэд. Хэрвээ зах зээлд шударгаар өрсөлдөж, бүх банкны картнаас ижил шимтгэл авдаг байдал бэлэн мөнгөний машинаа тохируулсан бол өчнөөн хөрөнгө үрж хэдэн арван машин нэг газар байрлуулж байрхах шаардлага байхгүй. Тэр мөнгөөр үйлчилгээгээ сайжруулах, хүүг бууруулах талаас ажиллаж болох байлаа. Хамгийн багадаа л гурван машин нэг газарт байрлах нь хангалттай баймаар. Хажууханд нь Худалдаа хөгжлийн банкны бэлэн мөнгөний машин хүнгүй байхад ХААН банкаас мөнгөө авахын тулд уртаас урт оочер үүсгэж зогсоно гэдэг луйвар биш өөр юу байх билээ. Цахим үйлчилгээний төлбөр буурах бус харин ч нэмэгдчихэж. Хамгийн сүүлд гэхэд л ХААН банкны АТМ-ээс бэлэн мөнгө авахын тулд 100-г биш 200 төгрөг төлөхөөр болжээ. Банк хооронд данснаасаа гүйлгээ хийхийн тулд 3000 төгрөг төлдөг буруу жишгийг ч тэд тогтоолоо. Гэтэл дэлхий дахинд зээл авах нь хүртэл автомат болох хэмжээнд



...Бид ломбардны зарчмаар ард түмнээ дарамталсан 14 банкны эздэд төртэй, түмэнтэйгээ дарамтуулчихаад сууж байгаа юм. Гаднаас банк орж ирэхийг төр нь биш тэд л шийдэж сууна. Улстөрчдийн амыг ард түмнийг шулж олсон мөнгөөрөө тагличихаад дотооддоо монополь эрх дархыг бий болгочихлоо...

хүрчихэж. Шинээр үүд хаалгаа нээж байгаа аж ахуйн нэгж зөвхөн банк. Хямралтай цаг үед хэдэн давхар өндөр хаус, барилга барьж байгаа ганцхан аж ахуйн нэгж нь банк гэдгийг худлаа гэж хэлэх хүн гарахгүй биз. Тэр ч байтугаа дампуурч байгаа банкууд маань том ордын хувьцаа эзэмших гэж улайрч, сонгуулийн өмнөхөн Эрдэнэтийн хувьцаагаар шуугиан тарив. Энэ нь дампуурлаа зарлаж буй банкны хийдэг ажил биш баймаар. Банкуудын жилийн цэвэр ашиг нь жилдээ 830 тэрбумаар тоологдож буйг Төв банкны цахим хуудаснаас бэлэн харж болно. Төв банкний өнгөрөгч жилүүдэд удирдаж байсан удирдлагууд иргэдийнхээ үүднээс шинэ хөтөлбөр эхлүүлсэн. Өөрөөр хэлбэл, зээл авах, зээлийн эргэн төлөлт, бэлэн мөнгөөрөө хэрхэн хуримтлал үүсгэх тухай мэдлэг, боловсролтой иргэдийг бэлтгэх үндэсний хэмжээний том хөтөлбөр эхлүүлсэн билээ. Үүнд хамгийн чухал үүрэгтэй оролдох цаг бол банк. Хөрөнгийн бирж, хувьцааны талаар төдийлөн ойлголтгүй иргэд өнөөдөр зөвхөн банкаас л зээл авах, банкинд хадгаламж, хуримтлал үүсгэх байдлаар харьцдаг учраас тэд нийгмийн хариуцлага ухамсарлаж энэ ажлыг гардан хийх учиртай. Харамсалтай нь тэдэнд тийм хүсэл алга. Үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар ажил эхлүүлсэн банк ганц нэгээр л тоологдоно. Тэдгээр хөтөлбөр нь мөнгийн нь хэрхэн банкинд авах вэ гэдэг хөтөлбөр болохоос та хэдэн төгрөгийн зээл авч, юунд зарцуулах, хүү нь хэрхэн бодогддог талаар мэдлэг олгож

байгаа газар нэг ч байхгүй. Иргэд санхүүгийн мэдлэггүй, зээлийн хүү хэрхэн бодогдох ёстойг мэдэхгүй байх тусмаа л тэдэнд ашигтай учраас цаашдаа ч энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хуруу гараа хөдөлгөх банк цөөхөн байх нь. 20 жилээр үл хөдлөх хөрөнгийн зээл авсан иргэн эхний 15 жилд зөвхөн банкны хүүг төлдөг улс манайхаас өөр байхгүй. Сарын 700.000 төгрөгийн цалин авдаг атлаа банкаас 1.5 сая төгрөгийн цалингийн зээл авч, доромжлуулдаг ард түмэн биднээс өөр үгүй. Хадгалуулсан мөнгөө авахын тулд хураамж төлдөг, цахим үйлчилгээ авсан ч, цалингаа авахын тулд ч мөнгө төлдөг хүдлэнгүй хүмүүс зөвхөн монголчууд. Ард түмнээс хууль бус мөнгө хураах нь зөв хэмээж төртэйгээ шүүхдэж даам гарсан банк ганцхан манайд л байгаа. Дотоодын банкны зээд гэгдэх хэдхэн гэр бүлд бүхэл бүтэн улсынхаа эдийн засгийг атгуулчихаад банкны эздийн хүсэл таашаалаар ажиллаж, хөдөлж, бодлогын хүүгээ дээш доош болгож, аж ахуйн нэгж, баялаг бүтээгчдээ биш арилжааны банкуудын төлөө шийдвэр гаргадаг төртэй улс ганцхан манайх. Бусад улс оронд санхүүгийн зах зээл хэтэрхий өндөр хөгжсөн. Тэр хэрээр гадны олон ч банк, санхүүгийн байгууллага чөлөөтэй үйл ажиллагаа явуулж, өрсөлдөөнийг бий болгодог. Иргэд хамгийн бага хүүтэй, уян хатан нөхцөлтэйг нь сонгож үйлчилгээ авдаг болчихоод байна. Гэтэл бид ломбардны зарчмаар ард түмнээ дарамталсан 14 банкны эздэд төртэй, түмэнтэйгээ дарамтуулчихаад сууж байгаа юм. Гаднаас банк орж ирэхийг төр нь биш тэд л шийдэж сууна. Улстөрчдийн амыг ард түмнийг шулж олсон мөнгөөрөө тагличихаад дотооддоо монополь эрх дархыг бий болгочихлоо. Бид дампуурах гээд байна бодлогын хүүгээ өсгөж, иргэдэд зээл өгөхгүй, аж ахуйн нэгж дампуурах нь бидэнд хамаагүй, орон сууцны зээл гаргахгүй байх нь бидний эрх, цалингийн зээл, тэтгэврийн зээлийн хүүг бууруулахгүй хэмээн хугацаанд бид ийм л замаар явж иржээ. Цаашдаа ч ингээд яваад байх уу. Ажлын цалингаар барьцаалж ард түмнийг шулдаг биш үндэсний хэмжээний бүтээн байгуулалт санхүүжүүлдэг, иргэдийн бодит орлогыг зөв үнэлж, үл хөдлөх хөрөнгөтэй болоход дэмжлэг үзүүлдэг, үйлдвэрлэлийг дэмждэг, эд хөрөнгийг нь бус оюун ухааныг нь төсөл хөтөлбөрийг нь барьцаалж зээл олгодог банк ус агаар шиг хэрэгтэй байна. Түүнийг дотоодоосоо эрээд ч хэрэггүй биз. Тиймдээ ч чөлөөт өрсөлдөөн бий болгож, банк санхүүгийн салбарт салхи оруулах цаг нь хэдийнэ болжээ. Тэр тусмаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар одоо гараа хөдөлгөх цаг нь болсон байна. Алийн болгон ломбардад дарлуулж суух билээ. Ард түмэн ядахдаа санхүүгийн талаар мэдлэгтэй болж, авсан зээлээ асуудалгүй төлж сууг. Бизнесийн зээлээ бага хүүтэй авч, банкны цахим үйлчилгээг ядахдаа

мөнгө төлөхгүй аваг. Дэлхийн банк санхүүгийн томоохон тоглогчид болох “Standard Chartered”, “Mitsubishi”, “ING”, “Mitsui”, “Sumitomo” зэрэг банкны төлөөлөгчийн газар Монголд байгуулагдсан ч банкны салбарын ноёрхол, эздийн хязгааргүй шунал хүслийг мэдэх учраас өнөө хэр салбар байгуулсангүй. Хятадын төв банк орж ирэх нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэх үзэл суртлын дайныг тэд л явуулж ирлээ. Цаашдаа ч явуулна. Гэвч алийн болгон монголчууд жалтын үзлээр сэтгэж, эх орондоо хайртай хэмээн олсон хэдэн төгрөгөө шулуулж суух билээ. Тиймээс салхи оруулж, өөрчлөлт хийх цаг болсон байна. Эс тэгвээс чөтгөрийн тойрог шиг дампуурын тухай яриа, зээлийн хүү өндөр байна гэсэн эцэс төгсөлгүй гомдолтойгоо дахиад ч нэг зууныг туулах биз.

### МЭДЭЭЛЭЛ

## J4 КОМПАНИЙН ГАДААД ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ ПАВЕЛ ПОЛАЧЕКТ “SILK ROAD” ОДОНГ ГАРДУУЛЛАА



Н.ПУНЦАГ

Бүгд найрамдах Чех улсын J4 компанийн гадаад худалдааны төлөөлөгч Павел Полачекийг Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын нэрэмжит “Silk road” шагналаар шагналаа. Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа очигдөр “Талх чихэр” компанийн байранд болсон юм. Энэхүү шагналаар хоёр улсын хамтын ажиллагааны хөгжилд хувь нэмэр оруулж буй хувь хүмүүсийг шагнадаг бөгөөд тэднийг урамшуулан дэмжих, нийтэд таниулах зорилготой юм байна. Шагнал гардуулах ёслолыг нээж, “Талх чихэр” компанийн гүйцэтгэх захирал М.Базар-Ууган үг хэлсэн. Тэрбээр “Юуны өмнө энд хүрэлцэн та бүхэндээ энэ оройн амар амгаланг айлтгая. Манай компани 2015 оны сүүлчээ шинэ төсөл хэрэгжүүлж эхэлсэн нь амжилттай болж, одоо гэрээнийхээ шатанд орчихоод явж байгаа билээ. Тоног төхөөрөмжийн утгалтаа энэ оны сүүлчээр хийх гэж байна. Чех, Итали, Герман гэсэн Европын орнуудын техник, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхэд нэвтрүүлж, Монголд байхгүй шинэ талх, нарийн боовыг үйлдвэрлэхээр зорьж байна. Өнөөдөр Чех улсын иргэн, бидний хэрэгжүүлэх шинэ төслийн гол төлөөлөл болсон Павел Полачек бидний урилгыг хүлээн авч, энд хүрэлцэн ирээд байгааг баяртай байна. Энэ дашрамд Монгол Улсын “Талх чихэр”, БНЧУ-ын J4 компанийн хамтран туулсан 12 жилийн түүх цаашид ч үргэлжлэх болтугай. Манай “Талх чихэр” компанийн дэд уриа байдаг. “Европ технологийг Монголд нутагшуулна” гэж. Энэ урианыхаа дагуу хүнсний бүтээгдэхүүнээ чанартай хийхийг зорих болно. Мөн энд нэг мэдээллийг дуулгахад, Олон улсын хүнсний аюулгүй байдлын стандарт буюу ISO22000-ийг манай үйлдвэр авч байгаа. Тэр ч утгаараа хүнсний аюулгүй байдлыг бүрдүүлэхэд чанартай, шаардлага хангасан Европ технологийг Монголд нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм” хэмээсэн. Түүний дараа Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга н.Оюундаш үг хэлэв. Тэрбээр “Талх чихэр” компани МХАУТ-ын иргэдийг гүйцэтгэж, Мөн манай танхимын үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцдог. Тиймээс би энэ компаниар бахархдаг. Өнөөдөр БНЧУ-ын J4 компанигай хамтраад зургаа дахь төслөө хэрэгжүүлж эхэлж байгаа юм байна. МХАУТ-ын нэг хийх ёстой ажил бол дэмжин урамшуулах. Тэгвэл өнөөдөр бид шинэ төслийг хэрэгжүүлэхэд болон Чех Монголын харилцааг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан J4 компанийн Гадаад худалдааны төлөөлөгч Павел Полачекийг танхимын нэрэмжит шагналаар шагнахаар болоод байна. Түүнийг эх орондоо буцаж байгаа энэ үеийг тохиолдуулан нэрэмжит шагналаа гардуулъя” хэмээгээд МХАУТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга н.Оюундаш Чех улсын J4 компанийн төлөөлөгч Павел Полачект “Silk road” одонг зүүж өгч, баяр хүргэсэн юм. Дашрамд дурьдахад, “Талх Чихэр” ХК нь Бүгд Найрамдах Чех

улсын J4 фирмтэй 2004 оноос хойш техник технологийн шинэчлэлийн томоохон төслүүдэд хамтран ажиллаж байгаа аж. Хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад анх удаа “Атар”, “Мишээл”, “Урган” зэрэг брэнд болсон талхнуудын үйлдвэрлэлийн болоод нарийн боовны үйлдвэрлэлийн иж бүрэн шугамуудыг ашиглалтад оруулж байж. Мөн Монголд анхны зүүсэн талхыг нэвтрүүлж, хэрэглэгчдэд өргөн баяр байсан үйлдвэрийг юм байна. “Талх Чихэр” компани талх, нарийн боов үйлдвэрлэлийн хамгийн чухал, сүүлийн дамжлага болох жигнэлтийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр олон улсад танигдсан, 22 жилийн түүхтэй J4 компанигай хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, компанийн хэмжээнд техник технологийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлсэн. Түүнээс гадна талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн үнэлж “J4” компанийн гадаад худалдааны төлөөлөгч Павел Полачекийг шагнасан гэдгийг онцлон дурьдаж байлаа. Шагналаа гардаг авсны дараа Чех улсын J4 компанийн Гадаад худалдааны төлөөлөгч Павел Полачек “Би хоёр жилийн өмнө “Талх чихэр” компанийн үйл ажиллагаатай танилцаж байлаа. Тэгвэл өнгөрсөн хугацаанд энэ компани маш олон бүтээн байгуулалтыг өрнүүлж, өсч дэвжиж чадсан байна. Энэ удаад бид талх үйлдвэрлэлийн шинэ төслийг эхлүүлэхээр гарын үсэг зурж, хамтарч ажиллахаар болсон. Хагас жилийн дараа гэхэд шинэ бүтээгдэхүүн гарч, хэрэглэгчдийн гарт хүрнэ. Яг ямар бүтээгдэхүүн гарах талаар ярих хэрэггүй болов уу. Мөн өнөөдөр намайг энэ нэр хүндтэй шагналаар шагнасанд үнэхээр баяртай байна. Бидний хамтын ажиллагаа цаашид ч амжилттай үргэлжилнэ гэдэг итгэлтэй байна” хэмээн сэтгэгдлээ хуваалцаа.

## УЛС ТӨР

Би МОНГОЛОО  
ингэж хөгжүүлнэҮргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Тосонцэнгэлээс Улиастай чиглэлийн 181 км хатуу хучилттай зам барих асуудал 2012 оноос эхэлж, яригдсан. 2012 оноос гэрээнүүд нь хийгдсэн ч дундаа хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэгч компаниудын асуудал зэргээс хамаараад зогссон байдаг. Намайг ажлаа авсан эхний өдөр БНХАУ-ын Элчин сайдын яамныхан бүрэн бүрэлдэхүүнээр ирж, бид хэлцэл хийсэн. Өмнө нь Тосонцэнгэл талаасаа Улиастай руу чиглэсэн 114 км замыг Хятадын хөрөнгөөр тус улсын компани засахаар шийдвэрлэсэн байсан. Энэ ажлыг түргэвчилж, наймдугаар сардаа багтааж эхлүүлэгч гэдэг хүсэлтийг Хятадын талд тавьсан. Хятадын тал болоод гүйцэтгэгч компанийн зүгээс бидний саналыг

дизель станцын түлшний нөөцийн асуудал тулгамдаж байна. Гэтэл 2016 оны төсөвт түлшний нөөцийг дөрөв дахин бууруулаад тавиад өгчихсөн байгаа. Одоогоор нөөцгүй болчихсон, нөхцөл байдал ийм байгаа учраас түлшний асуудлаа шийдүүлэхээр Засгийн газарт болон Эрчим хүчний сайдад асуудлаа тавьсан. Эрчим хүчний сайд түлшний асуудлыг шийднэ гэдгээ хэлсэн. Үндсэндээ асуудал ийм байна.

**-Энэ жил танай аймагт хэдэн тооны мал өвөлжих вэ. Хадлан тэжээлийн нөөц бэлтгэх ажил хэр явагдаж байна. Энэ өвөл их хүйтэрийн зэрэгцээ бичин жилийн зуд болж ч мэднэ гэж яригдаад байгаа шүү дээ?**

-Ер нь амны бэлгээс ашдын бэлгэ гэдэг. Аливаа зүйлийг гэгээн сайхнаар бодож чадвал үйл нь бас



## Д.БАТСАЙХАН:

## ХӨГЖЬЕ ГЭВЭЛ ӨӨРЧИЛ ГЭСЭН ҮГ БАЙДАГ ШҮҮ ДЭЭ

хүлээж авч, энэ замын ажил одоо эхлэх гэж байна. Энэ бол 2015 онд Засгийн газрын тогтоолоор хөрөнгийн эх үүсвэр нь шийдэгдэж, сая АСЕМ-ын үеэр гэрээ нь эцэслэн батлагдаж, асуудал нь шийдэгдсэн зам байгаа юм. Энэ 114 км-ээ цааш үргэлжлэх Загастайн давааны 67 км замын асуудал нэлээд хүнд байгаа. Энэ бол уулын, маш хүнд нөхцөлтэй зам боловч 2012 онд гэрээ нь байгуулагдаж, Хөгжлийн банкны эх үүсвэрээр барихаар болсон юм билээ. Гэвч гүйцэтгэгч талын буруутай үйлдэл байна гээд гэрээг цуцалсан байдаг. Дахиад өөр нэг компанитай гэрээ байгуулсан боловч энэ замыг барихад 41 тэрбум төгрөгийн эх үүсвэр дутагдалтай гэсэн нөхцөл байдалтай байгаа. Энэ эх үүсвэрийг хэрхэн, яаж шийдэх вэ гэж Засгийн газар, яамдын удирдлагуудтайгаа уулзаж, олон талаас нь хэлэлцэж байна. Энэ 41 тэрбум төгрөгийн сөн тэрбумыг 2016 оны төсвийн тодотголд тусгахаар Засгийн газрын шийдвэр гарчихсан. Үлдэж буй хөрөнгийн асуудлыг Хятадын хөнгөлөлттэй зээлийн хэмнэгдсэн хөрөнгөөс шилжүүлэн шийдвэрлэх талаар Засгийн газрын хуралдаанд саналаа орууллаа. Энэ шийдвэр гарвал 41 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрэн шийдэгдэж, замын ажил эхлэх боломжтой болно. Хэдийгээр хатуу хучилттай зам барих асуудлын хөрөнгийн асуудал шийдэгдэж байгаа ч гэсэн энэ хавартаа эхлэх боломжгүй. Ирэх хавраас л замын ажил эхэлнэ. Тэгэхээр энэ өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд давааны зам дээр сайжруулалт хийх зайлшгүй шаардлага тулгараад байгаа. Манай аймаг бас Загастайн давааны замаар 300 км газраас нүүрсээ татдаг. Тийм учраас аймгийн Онцгой комиссыг хуралдуулж, Засаг даргын захирамж гарч, өндөржүүлсэн бэлэн байдал зарлалаа. Энэ хүрээнд Загастайн давааг дамнансан 67 км замыг хусах, сайжруулах замаар зам засвар, арчлалтын ажлыг өөрсдийнхөө хүчээр хийхээр шийдсэн. Энэ ажил есдүгээр сарын эхээр хийгдэж эхэлнэ. Ингээд өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангахивал ирэх хавраас хатуу хучилттай замын ажил маань эхэлчихнэ гэж бодож байна.

**-Замны асуудлаас гадна өөр тулгамдаж байгаа асуудал юу байна?**

-Замны асуудлаас гадна Улиастай сумын 1.2 км-ийн цэвэр бохирын шугамын асуудал байна. 35 жил гар хүрээгүй, хүүхдийн зулай шиг болчихсон шугам бий. Мэргэжлийн байгууллагын зүгээс энэ шугам өвлийн ачааллыг даахгүй гэсэн дүгнэлт гаргасан. Энэ асуудлыг шийдэхийн тулд Засгийн газартаа асуудал тавьж, Ерөнхий сайдад хүсэлт гаргасан. Засгийн газрын ноёд сангаас энэ ажилд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гаргаж өгөхийг хүссэн. Энэ асуудал шийдэгдэх байх гэж бодож байна. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдвэл өвлөөс өмнө шугам засварын ажлыг хийж, гүйцэтгэнэ. Бас нэг тулгамдаж буй асуудал байгаа нь эрчим хүч. Манай аймгийн хувьд төвийн эрчим хүчний систем, усан цахилгаан станцаар хосолж явдаг боловч өвлийн өндөр ачаалалтай үеийг дизель станцаар давахаас өөр арга байдаггүй. Тиймээс

гэгээн байдаг. Тийм учраас манайхан харьцангуй гэгээлэг хандаж байгаа. Тэгэхдээ өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангаж, хадлан тэжээл, өвсөө сайн бэлтгэх ёстой. Малчид маань энэ ажилдаа орчихсон. Засаг даргын хувьд албан даалгавраа гаргаж, өвөлжилтийн бэлтгэлээ хангахыг үүрэгдсэн. Үүнээс гадна өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах Ажлынхэсэг байгуулж, төлөвлөгөөг гаргасан. Ажлын хэсгийн гишүүд маань сумдаар явж, өвөлжилтийн бэлтгэлийг бодитоор нь хангасан эсэхийг шалгана. Малчин өөрөө бэлтгэсэн өвсийг сумын нөөц гээд бүртгэгчид асуудал байдаг. Тэгэхээр хамгийн анхан шатанд буюу малчдын хотонд байгаа нөөц, түүнээс үл хамаарах байдлаар сум, аймаг, улсын нөөцийн өвс тэжээлийг бэлтгэх гэсэн дөрвөн үе шаттайгаар өвс тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж, хийж байна.

**-Эдийн засаг хүндрэлтэй байна. Аймаг битгий хэл улсаараа зардлаа танаж, төсвөө хэмнэе гээд байгаа. Тэгэхээр танай аймгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хэр байна?**

-Төсвийн хувьд хаа хаана л хүнд байгаа. Миний нэг бодож явдаг зүйл бол заавал эдийн засаг хүндэрчихлээ гээд төсвөө танидаг асуудал сайн зүйл биш юм шиг байгаа юм. Ер нь төсвийн үр ашигтай зарцуулалтын тухай асуудал бол мөнхийн сэдэв байх ёстой. Аймгийн гаргаж буй зардал, улсын төсвийн гаргаж байгаа зардал ялгаа байхгүй сайн, муу гэсэн хоёр төлөвтэй байдаг. Тиймээс аль болох муу зардлаа багасгаж, сайн зардлаа дэмжих замаар эдийн засгаа тэтгэх л бодомж тогтвортой, урт хугацаанд хэрэгжүүлэх ёстой. Манай аймгийн хувьд ч муу зардлууд бий. Тэр муу зардлуудаа олж илрүүлээд, түүнийг хэмнээд, аль болох өөр зардлаар солих, сайн, үр дүнтэй зардлуудаа саадгүй санхүүжүүлэх хэрэгтэй. Ер нь ийм л замаар өрх гэрээс эхэслүүдэл улс орон хөгждөг жамтай. Тэгэхээр төсвийн хувьд манайх хүндрэлтэй л аймаг. Өөрийн орлого багатай, татаастай амьдардаг, аялалдсан бүс нутагт байрладаг аймгуудын нэг. Үүнээс гадна манай аймаг бол хамгийн олон сум, багтай. Сум болон баг хоорондын зай маш хол. Нэг сумаас баг руугаа хүртэл 200-300 км явдаг. Энэ бүхнийг дагаад, дэд бүтцийн сул дорой байдалаас үүссэн зардлын нэмэгдлийг бий болгож байдаг. Уул даваа ихтэй, огцом хад цавчил ихтэй болохоор тээврийн болоод сэлбэг хэрэгслийн зардал өндөр гардаг. Хэдийгээр ийм онцлогтой ч гэсэн үүндээ тохирсон зардлын норматив тогтоох замаар зохистой зарцуулалтын асуудлыг шийдэх ёстой. Орон нутгийн хөгжлийн сан нэлээд сул байгаа. Манай улсын төсвөөс авах ёстой Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр дутуу явж байна. Очсон мөнгөний зарцуулалт ч тийм хангалттай биш байна. Тийм болохоор Орон нутгийн хөгжлийн сан дээр онцгой анхаарна гэсэн бодолтой байна. Сая Сангийн яамныхангай уулзаад, дутуу санхүүжилтээ олгооч ээ гэсэн саналаа тавьсан. Очиж байгаа мөнгийг аль болох үр дүнтэй зарцуулах, менежмент тал дээр илүү анхаар гэсэн зөвлөмжийг

өглөө.

**-Ерөнхийдөө аймаг бүрт гадны төсөл хөтөлбөрүүд нэлээд хэрэгждэг. Зарим аймаг төсөл хөтөлбөрүүдийг татаж, аймагтаа тулгамдаж буй асуудлаа шийдчихсэн нь ч байдаг. Танай аймгийн хувьд гадны төсөл хөтөлбөрүүдээс хэрэгжиж байгаа хэд байна. Төсөл хөтөлбөрүүдийг татсаанаар хөрөнгө санхүүгээ нэмэгдүүлэх боломж хэр байна вэ?**

-Гадаад харилцаан дээр нэлээд онцгой анхаарах ёстой. Сая намайг ажил авсны дараа Германы болон Японы төслийнхон ирж уулзлаа. Аль алинтай нь Завхан аймгаа хөгжүүлэхэд чиглэсэн олон талт хамтын ажиллагааг өрнүүлнэ гэсэн саналууд солилцсон. Хятадын Элчин сайд бүх атташе, зөвлөхүүдтэйгээр ирж уулзсан. Хятадтай бас эдийн засаг, худалдаа, соёлын салбарт хамтран ажиллах чиглэлийн саналуудыг мөн солилцсон. Одоохондоо санал солилцох төвшинд байна. Ер нь манайд бол гадаад харилцаа нэлээд чухал. Тэгэхдээ манай аймгийн хувьд бол хилийн боомтгүй, газар нутгийн хувьд сонин байрлалтай, төвлөрсөн зах зээлийн эдийн засгаас хол зэрэг сул талтай. Энэ сул талаа хэрхэн, яаж давуу тал болгох вэ гэдэг дээр л оюун ухаанаа урагдуулах шаардлага байна гэж харж байгаа.

**-Баруун бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төслийн хүрээнд өнгөрсөн жил Ховд, Баян-Өлгий аймгийг хатуу хучилттай замаар холбох ажил эхэлсэн. Энэ үеэр Ховд, Завхан аймгийг холбох боломжтой гэсэн мэдээлэл гарч байсан. Хэрвээ энэ асуудал ажил хэрэг болбол хилийн боомттой ойрхон болох боломж гарч ирэх юм биш үү?**

-Тэгэлгүй яах вэ. Завхан аймагт болоод завханчуудад хэрэгтэй бүх л санаачлыг дэмжинэ. Ховд аймагтай холбогдох замаар баруун хилийн ойртуулах, хилийнхуудалдааг хөгжүүлэх шаардлага бий. Бас Говь-Алтай аймагтай хатуу хучилттай замаар холбогдох шаардлага байгаа. Говь-Алтай аймагтар дамжуулаад урд хил рүү гарч, хилийн худалдааг өргөжүүлэх боломжтой. Мөн Говь-Алтай-Завхан-Хөвсгөл гэсэн аялал жуулчлалын шинэ маршрут бий болгох бололцоо ч бий. Тосонцэнгэл, Улаангомь холбосон хатуу хучилттай замын ажил бас явж байгаа. Дэд бүтцийг хөгжүүлчлэх үүнийг дагаад нэмэгдүүд нэмэгддэг учраас Завхан аймагт болоод завханчуудад хэрэгтэй харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.

**-Зам сайхан болохын хэрээр монголчууд маань эх орныхоо үзэсгэлэнт газруудаар аялахыг чухалчилдаг болчихсон. Гэтэл амарч, аялж яваа хүмүүст үйлчлэх аялалт газар, боловсон 00 алга. Энд тэндгүй хогийн цэг үүсчихсэн, замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй, хүмүүс нэгнээсээ зам асуух маягтай явж байгаа нь харагдлаа. Эдгээр асуудлыг шийдээгүй цаг аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар яриад үр дүн гарахгүй байх гэж бодогдох юм. Таны хувьд?**

-Тантай санал нэг байна. Аялал жуулчлал дээр гурван үндсэн асуудал байгаа гэж би хувьдаа харж байгаа юм. Нэгдүгээрт, дэд бүтцийн

асуудал. Зам муу, агаарын тээвэр сааталтай, эрчим хүчгүй байгаа нөхцөлд аялал жуулчлал хөгжих бололцоо муутай. Хоёрдугаарт, үйлчилгээний соёл байхгүй. Үйлчилгээний соёлын хамгийн наад захын жишээ өөрийн тань хэлж байгаа зүйлүүд. Замын тэмдэг тэмдэглэгээгээ эхлээд чиглэл, км-ын заалт зэргийг нэг их мөнгө орохгүйгээр шийдчих бололцоотой асуудал шүү дээ. Дээрээс нь аялал жуулчлалын маршрут, пар гэдэг зүйл бас байхгүй байна. Үүнийг шийдэхээр хүмүүстэй ярихцаад, энэ сарын сүүлээр манай аймагт аялал жуулчлалын маршруттар Google map хийх гэж байна. Үүнийг хийснээр аялал төлөвлөх бололцоог бий болгоно. Гурвалдугаарт, кемпийн асуудал байгаа юм. Стандартын шаардлага хангасан, эрүүл ахуйн орчин, үйлчилгээний соёл маш дутмаг байгаа учраас үүнд хүмүүсээ сургах, бас юм үзүүлж, нүд тайлуулахын зэрэгцээ стандартыг бий болгох зайлшгүй шаардлагатай. Үүний зэрэгцээ аялал жуулчлалыг төрөлжүүлэх шаардлагатай байгаа. Захын суманд очоод л морь унадаг байх юм бол тэр олон км замыг туулж, олон суманд очих шаардлага байхгүй шүү дээ. Тийм учраас сум суманд үзэх зүйлгүй байлгах, үйлчилгээний онцлогийг бий болгох, өртөөчилсөн аялал хийх боломжийг бий болгох хэрэгтэй гэж бодож байгаа.

**-Сая АН-ын хэрэгжүүлж байсан "Сайн малчин", "Сайн оюутан" хөтөлбөрүүдийг зогсоочихлоо. Малчид хүү багатай эзлээ авч чадахгүй, оюутнууд сургалтын төлбөрөө хаанаас олохоо мэдэхгүй байдал орлоо. Дээрээс нь малын түүхий эд, нэхий өлөнг нь авхаан болчихсон, малчид нэхийгээ хураачихсан, их л бухимдалтай байна билээ?**

-Хүмүүст дандаа боломж олгож байх ёстой гэж би боддог л доо. Сайн хөтөлбөрүүд бол их үр дүнтэй, бас ард иргэдэд өгөөжтэй хөтөлбөр байсан. Энэ хөтөлбөрийн тухайд макрон эдийн засгийн төвшинд шийдэх ёстой асуудал байсан байх. Тэгэхээр хөтөлбөрөө зогсоож асуудлаа шийдэх үү, эсвэл макро төвшиндөө асуудлаа шийдэхийн тулд хөтөлбөрөө зогсоох уу гэсэн сонголтын өмнө тулж ирээд хөтөлбөрөө зогсоогөдгээ сонголтыг хийсэн нь маш харамсалтай. Тэгэхдээ эдгээр хөтөлбөрүүдийг цааш нь үргэлжлүүлэх байх гэж найдаж байна. Угаасаа хүмүүсийн хэрэгцээ хаашаа байна, тийшээ үйлчилгээ явдаг зах зээлийн хуультай учраас макро эдийн засаг дээрээ гаргалгаагаа хийж, зохицуулалтаа шийдчих юм бол хөтөлбөрөө үргэлжлүүлсэн нь ард түмэнд нааидалтай гэж бодож байна. Мөн малчин хотонд хот айлд зориулсан жижиг цех хэрэгтэй байгаа юм. Учир нь нэхийний үнэ уначихсан, малчид хотондоо нэхийгээ өрөөд тавьчихсан байж байна шүү дээ. Нэхий чинь маш богино хугацаанд борлуулж чадахгүй бол үнэгий болчихдог түүхий эд. Тэгвэл нэхийг үнэтэй байлгахын тулд боловсруулдаг анхан шатны жижиг цехийг хот айлын дунд бий болгох юм бол түүхий эдээ үнэгүйдүүлэхгүй байх боломжтой. Тэгэхээр төр бүхнийг хийдэг биш малчид өөрсдөө бас санаачилга гаргаад, өөрчлөлтийг

хийх хэрэгтэй.

**-Алслагдсан аймаг гэдэг утгаараа эрүүд мөндийн асуудал нэлээд хүндрэлтэй юм билээ. Ховд аймагт Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг байгуулахаар ярьж байгаа гэдийг ч саяхан барилга барих гүйцэтгэлийг сонгон шалгаруулж, 2017 онд ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах үүрэг өгч байгаа харгасан. Тэгэхээр завханчууд заавал Улаанбаатарт ирж үзүүлж, оношлуулах болж байгаа нь хүндрэлтэй санагдсан?**

-Энэ бол маш их тулгамдаж буй асуудал. Хол зам туулж, маш их зардал болж ирдэг. Энд ирсэн хойноо эмнэлгүүдийг тойрч явсаар очооч дараалал хүлээж маш их цаг алддаг. Тийм учраас АН мөрийн хөтөлбөртөө энэ эмнэлгийн оношлогоо үйлчилгээг онлайн хэлбэрт оруулах замаар Улаанбаатарт ирж оношлуулдаг биш Улиастайд оношлуулдаг болно гэж багтаасан. Мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. ЭМЯ-д саналуудаа тавина. Техник технологийн шинэчлэлийн асуудал, эмнэлгүүдийн хоорондын уялдаа холбоо маш дутмаг байгаа. Тэгэхдээ үүнийг дан ганц Завхан аймаг дангаараа шийдчих асуудал биш. Хэрвээ ингэж шийдэж чаддаггүй юм бол тодорхой эх үүсвэр шийдэх замаар Завханаас Улаанбаатарт ирж оношлуулж байгаа энэ хүмүүсийн нэг цэрт төвлөрүүлээд, нэг цэгээс бүх үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай юм байна гэж би хувьдаа бодож байгаа. Үүнийг хувийн хэвшлийнхэнтэй хамтарч хийж болох байх гэж найдаж байна.

**-Сургууль, цэцэрлэгийн асуудал харьцангуй гайгүй боловч боловсон хүчний асуудал нэлээд дутмаг байна уу даа гэж харж байлаа?**

-Сургууль цэцэрлэгийн хүрэлцээ гайгүй боловч баг нарын ур чадварын асуудал, боловсон хүчний нөөц бололцоо дутмаг, тэдний санаачилгыг нэмэгдүүлэх, сэтгэлзээсээ ажиллах шаардлага бий. Тиймээс боловсролын байгууллагад нэлээд шинэчлэл хийнэ гэсэн бодолтой байна. Одоогоос 14 жилийн өмнөөс би Завхан аймагт математикийн олимпиадыг зохино байгуулж, тасралтгүй явуулсан. Боловсролын салбартай нэлээд ойрхон байдаг болохоор хүүхдэд хөгжүүлэх, хүнээ хөгжүүлэх тал дээр онцгой анхаарна. Завхан нутгийн тогтвортой урт хугацааны хөгжил бол хүний хөгжил гэж харж байгаа. Тийм учраас боловсролын салбарт маш их анхаарна.

**-2016 он бол сонгуулийн жил. Тэгэхээр өнгөрсөн дөрвөн жил Завхан аймаг МАН-ын удирдлагатай байсан. Харин энэ дөрвөн жил АН-ын удирдлагатай байх нь. Нам солигдохоор намаар ялсварлах, ажил албан тушаалын томилгоо хийгдэх, халаа сэлгээ хийх зэргээр олон асуудал өрнөдөг. Танай аймгийн хувьд энэ асуудал хэр байна?**

-Мэдээж хэрэг өөрчлөлтүүд хийнэ. Тэгэхдээ хүнс солиод өөрчлөлт хийнэ гэхээсээ илүүтэй ажил явуулахын тулд сайн баг бүрдүүлж, ур чадвартай хүмүүст салбаруудаа хариуцуулах шаардлагатай байдаг учраас тодорхой хэмжээний

өөрчлөлт хийх нь мэдээжийн хэрэг. Ялангуяа хөгжлийн хувьд буурай байгаа аймгийн хувьд огцом, хурдтайхан өсөлт хөгжлийг авчирар гэж зорьж байгаа учраас өөрчлөлт хийж л таарна. Тэгэхдээ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх газрыг сольж холино гэсэн үг биш. Ажил нь явахгүй байгаа, шинэчлэл өөрчлөлт зайлшгүй шаардлагатай газруудад л өөрчлөлт хийнэ. Ер нь хөгжье гэвэл өөрчил гэсэн үг байдаг. Өөрчлөлт гэдэг бол хүн өөрчлөхөөр тогтохгүй, тогтолцоо, бодлого, процедурыг өөрчлөх гээд олон өөрчлөлт энд хамт яригдана.

**-Тун удахгүй орон нутгийн сонгууль болох гэж байна. Танай аймагт орон нутгийн сонгуулийн уур амьсгал орчихсон байна уу?**

-Одоо орон нутгийн сонгууль эхэлнэ. Аль аль намууд бэлтгэлээ хангаж, мөрийн хөтөлбөрөө боловсруулаад аудитын байгууллагад хүргүүлэх хуулийн хугацаа энэ сарын 19-ний өдөр дууссан. Нэр дэвшүүлэх процедурууд одоо эхэлнэ. Тэгэхээр энэ бол манай нутгийн удирдлагуудын нэг онцлог сум сум өөрийн гэсэн нутгийн удирдлагын тогтолцоотой. Энэ бол хэнээс ч хараагт бус тийм тогтолцоо. Ингээд орон нутгийн сонгууль амжилттай явагдаж өндөрлөх байх гэж бодож байна. Олон сайхан оюун ухаан урагдуулсан, нэр хүндтэй хүмүүс шударга өрсөлдсөн сонгууль болох байх.

**-Таны хувьд ирэх дөрвөн жил аймаг, орон нутгаа хөгжүүлэхийн тулд ямар ажлуудыг хийхээр төлөвлөдөг байгаа вэ?**

-Олон зүйл байна. Хамгийн эхний бодож байгаа зүйл бол хүний хөгжил. Хүнээ хөгжүүлсэн улс орны хөгжил өндөр байдаг учраас хүмүүсээ хөгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг талхуу хийх ёстой. Ерөнхийдөө эдийн ядуурлаас сэтгэлзээний ядуурал илүү байгаа нөхцөлд хүмүүсийг сэтгэлзээр баян, сэтгэлзээгээр мөнгө олох арга хэрэгслийг бий болгох тал руу нь нэлээд анхаарах ёстой юм болов уу. Эдийн засгийн секторын хувьд манай аймаг бол ялт ч үгүй хөдөө аж ахуй, мал аж ахуй дээрээ суурилж, хөгжих ёстой гэж үзэж байгаа. Мөн аялал жуулчлал манай аймгийн хувьд хөгжлийн том гарц болсон салбайх байх болно. Ер нь хэрэглээг аймагтаа үйлдвэрлэдэг аймаг руу шилжиж, хөгжих учиртай. Хүмүүсийн амьдрах орчин, нөхцлийг сайжруулахад мөн анхаарах ёстой. Залуучууд яагаад Завханд үлдэхгүй, хот руу шилжээд байгаа юм бэ гэхээр амьдралын орчин нөхцөл тааруу, ажлын байр хомс байгаагаас шалтгаалж байгаа. Тиймээс энэ асуудалд ч мөн анхаарах хэрэгтэй байна. Шийдэх зүйл маш их байгаа.

Мэдээж хэрэг эдгээр шийдэх зүйлүүд хэрэгжих боломж нөхцөл, санхүүгийн эх үүсвэр гэх мэтчилэн олон хүчин зүйлээс хамааралтай. Аймгуудийн санхүүгийн бие даах эрх чөлөө бас хомс байна. Ялангуяа гадаад улс орнуудтай бие даагаад харилцах боломж хомс. Бүх зүйл нь төвөөсөө хараагт, санхүүгийн тэтгэлэг татаасууд төвлөрсөн төсвөөс хамааралтай байгаа нөхцөлд санасан бүхнээ хэрэгжүүлэх бололцоо их тааруу байна. Тэгэхдээ мэдээж боломжтой бүхий л төвшинд урагшуулахын тулд хичээн, зүтгэж ажиллах болно оо.

# ОНЦЛОХ ХУУДАС

## ӨҮЙ ГҮ ӨҮЙ АҮ?



# ТЭНЭГЛЭЖ БАС ТЭСЭРЧ ЧАДДАГ У.ХҮРЭЛСҮХ

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

“Монголын мэдээ” сонин “Хэн нь хэн бэ” булангаараа “Мэргэжлийн” гэх тодотголтой Засгийн газрын сайдуудыг хүргэж байгаа билээ. Хамгийн эхний дугаартаа Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг онцолсон бол энэ удаагийнхаа дугаарт энэ Засгийн газрын “ээж” болох Шадар сайд У.Хүрэлсүхийг онцолж байна.

### Улс төрд хаалга тогшилгүй орж ирсэн нөхөр

МАХН-ын бурхиуд “Улс төрд хаалга тогшилгүй орж ирсэн” нөхөр хэмээж, ад үзэнгүй байсан ч чухамдаа 22 настай цэргийн бага даргыг дарцаг барих хэмжээнд хүртэл хөөрөгдөж, тархийг нь угааж, намын элгэнд нааж чадсан хүмүүс бол МАХН-ын тухайн үеийн нөлөө бүхий кадрүүд. Өөрөө ч түүнийгээ “Өчүүхэн жижиг завтай нэг муу хүүг улс төр гэдэг том далайд гаргаж өгсөн хүн бол Б.Даш-Ендон, Н.Багабанди, Н.Энхбаяр гурав” хэмээсэн байдаг. Харин тэр эдүгээ дарцаглаж давхис бус бусдыг харин дарцаглуулах хэмжээний улстөрч болсон. Нэгэн цагт Ардын армийн 152 дугаар ангид улс төрийн орлогч явсан залууг 1991 онд МАХН-ын Төв хороонд улс төрийн ажилтан болж, суга дэвшин намын аппаратын халуун тогоонд гурван жил буцлахад тухайн үеийн МАХН-ын удирдлагууд УИХ дахь МАХН-ын бүлгийн ажлын албанд зөвлөх болгож, өөд татсан байдаг. Дараа нь МАХН-ын Залуучууд хөгжил төвийн Ерөнхий захирлаар томилогдсон. Энэ үеэс л тэрбээр намынхаа нөлөө бүхий хүмүүстэй ойртож, тэдний хүрээлэлд багтсан юм билээ. Түүний улс төрийн намтар энгийн талдаа. Гадаадд их, дээд сургууль төгссөн, угсаа гарвал нь тайж энэ тэр гээд онцлоод байх зүйлгүй. Өөрийнхөө гаргасан жимээр өөрийнхөөрөө өгсч яваа улстөрч. МАН-ын түүхэнд нэрээрээ бичигдэж үлдэх хэд хэдэн зүйлтэй. Монголын ардчилсан социалист залуучуудын холбоог тэр үүсгэн байгуулж, ерөнхийлөгчөөр нь ажилласан. Зүүний хүчний холбоо гэгчийг байгуулсан нь эдүгээ МАН-ын бодлогод аль ч талаараа нөлөөлөх болсон. УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд гээд түүний дээшээ өгссөн жамнал бусдыг бодвол сонирхолтой.

### Тэнэглэж бас тэсэрч чаддаг У.Хүрэлсүх

Монгол Улсын Шадар сайдын улс төр дэх замналыг товчхон дүгнэхэд ийм. Улстөрчийн хувьд энэ бол ховор шинж чанар юм гэнэ лээ. Хамгийн гол нь тэрхүү тэсрэлтүүд банз, бай хоёрыг зэрэг онодогт л хэргийн учир орших нь бий. Шулуухан хэлэхэд, Ухнаагийн Хүрэлсүх гэх бузигнуулдаг нөхрийн гаргасан жимээр МАН-ын залуу кадрүүд эдүгээ тэнгэрт суудал засан тухалж буй. МАН “Х” үсгээсээ ангижирч чадаагүй, урт шар дээлтээсээ салаагүйсэн бол улс төрийн энэ хүчний нэр нүүр, үзэл баримтлал хаашаа эргэх байсныг хэн мэдлээ. Нам шинэчлэгдэх цаг болсныг ил тодоор зарлаж, намынхаа даргын өөдөөс дуутарч, Н.Энхбаярыг байдалд оруулж чадсан хүн бол У.Хүрэлсүх. Хүнд хэцүү цаг үед МАН-ын генсекээр ажиллаж, намын тогоо шангаатай зууралдаж, онгорхой цоорхойг нь оёх цаашлаад дүрсгүй чих халууцуулах нөхөдтэй тулж ажиллан, заримынх нь хандыг хага дараад

зогсохгүй халуун нурман дунд хөсөр хаягдан тэвдэж явахад нь орох орон оочих аягатай /Тусгаар тогтнолын ордон/ болгосон гавьяа түүнийх. Энэ гавьяаг нь хэн ч хуваалцах эрхгүй билээ. “Намын нэрийг сольсноор ялагдвал би харинудлага хүлээнэ” гэхийгээд УИХ-ын гишүүн хэмээж явах нь байж болшгүй зүйл хэмээгээд өөртөө харинудлага тооцон УИХ-ын гишүүний сэнтийгээ татгалзаж чадсан цорын ганц түшээ бол мөн л Хүрэлсүх. Улстөрчийн ийм эр зоригийг чухамхүү тэр л гаргаж чадсан юм. Эл алхмынхаа дараа намынхаа онц Их хурлын үеэр МАН-ын даргад нэрээ дэвшүүлэн эдүгээ УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан, УИХ-ын дарга М.Энхболд, С. Баяр нартай өрсөлдсөн. Намын даргын албан тушаалыг гартаа авч УИХ-ын ээлжит сонгуульд ялалтад хүргэх нь Монголын улс төрд хэн болохоо харуулах гэсэн улстөрчийн нүүдэл хэдий ч өөрийн тойрон хүрээлэгчдийг хүчирхэгжүүлэх гэсэн хүсэл, шуналаасаа болж хоосон хоцорсон. Ингэж л тэрбээр нөлөөт толиндоо буруу харж, том тэнэгтсэн удаатай. Үүнийгээ тэрбээр өөрийг нь “дараад” байсан хуучууд МАХН руу холбирах болсныг У.Хүрэлсүхийн улс төрийн карьерт том орон зайг бэлдэж өгч байгаа хэрэг гэж тооцоолсон ч байж мэднэ. Учир нь Н.Энхбаяр, С.Баяр нарын үед хөл гар нь хүлээстэй байсан бол С.Багболдын үед зөвхөн тархиа атуулчихаад байсан юм. Ө.Энхтүвшингийн хувьд У.Хүрэлсүхийн хувьд “хөнгөн зууш” байсан нь мэдээж. Дээр нь харинудлагаа хүлээж, УИХ-ын гишүүнээс хүртэл татгалзсанаараа нэр хүндээ өсгөж, бас “тэвэрлэж” авсандаа хэт бардсан хэрэг. Ийм шийдвэрийг гаргахад тухайн үеийн нам доторхи “Хотын фракци”, “МГИМО”, “Сү-ийн хүмүүс” гээд бүгд ялагдлын шокоосоо гарч чадахгүй, эв нэгдэл гэхээс илүү бизнесээ хөөж, тарж бутарсан зурвас үе ч боломж мэт санагдаа биз. Энэ мэтчилэн тэрбээр улс төрд унаж босч, ухарч урагшилж яваа нэгэн. Дугаар ангийн бага даргаас УИХ-ын гишүүн, сайд, МАН-ын генсек, Монгол Улсын Шадар сайдын албыг хоёр дахь удаагаа хашиж яваа түүний улс төрийн түүх ерөнхийдөө нэг иймэрхүү.

### Жолооч аавын улстөрч хүү

Түүний угсаа гарвал эгэл ард. Өвөг дээдэс нь ч тэр. У.Хүрэлсүхийг Сүх жанжны ижий, “Цагаан дээлт” Дамдины эхнэр Хандтай эцгийн талаараа ойрын төрөл гэгцгээх юм билээ. Тэгэхээр уугуул суугуул нутгийн хувьд Сүхбаатар аймгийн гаралтай байж болох ч өвөг дээдсийнхээ өлгий нутгийг Хэнтий хэмээн онцолсон байсан. Тэрбээр 1968 оны зургадугаар сарын 14-нд нийслэл Улаанбаатар хотод төржээ. Хүрэлсүхийн бага нас тэврийн жолоочийн гэрийн хойморт өнгөрсөн. Багадаа тэвэг өшиглөж, дургүйг нь хүргэсэн нэгнийг сэм авчихдаг хүү явсан гэнэ лээ. Тийм учраас эцэг нь түүнд хүмүүжил хэрэгтэйг олж харчихаад цэргийн сургуульд элсэхийг зөвлөсөн ч юм бил үү. Хүүхэд насны нударгаар шийддэг

араншингаа мань эр үе үе гаргах нь бий. Миний санахын УИХ-ын гишүүн асан Э.Мөнх-Очирыг өрөөндөө дуудаж байгаад цохисон гэж гишүүд хоорондоо ярьдаг. Асуудал үүгээр дуусахгүй, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны үеэр Г.Баярсайхан гишүүнийг салаавч гаргалаа хэмээгээд Төрийн ордонд сэтгүүлчдийн өмнө шанаа “өгсөн” түүхтэй. Үүнийгээ “Би цэргийн алба хаасан эр хүн. Доромжлолыг тэвчсэнгүй ээ. Өнөөдрийн үйл явдлын төлөө би та бүхнээс уучлал гуйж байна. Тэвчээрт хязгаар бий” гэж тайлбарласан. Улстөрчид У.Хүрэлсүхийг “офицер” хэмээн цоллодог нь эндээс эхтэй байх. Харин хүн чанарын тухайд Монгол Улсын Шадар сайдыг муулах зүйл үгүй. Түүний тус дэмийг хүртсэн, ямар ч тохиолдолд нэг л зангаараа байдаг гэхчилэн дандаа л магтаалын үгс урсч байдаг. УИХ-ын гишүүн Л.Гүндалайн амийг аврах ажлыг өөрөө зохион байгуулж, түүний халуун гараас атгаж байсныг нь, түймрийн голомтод ажиллан ОБЕГ-ыг техникийн хувьд шинэчлэх цаг болсныг ард түмнээсээ нуулгүйгээр зарлаж байсныг түмэн мартаагүй. Үнэндээ энэ эрхэмтэй шадарласны хувьд суга дэвшсэн нөхдүүд улс төрийн хүрээнд олон бий. Эдийн засгийн ашиг сонирхлын хувьд ч элдэв юм дуулдаггүй. Хотын төвд тэрбумаар үнэлэгдэх объектод цаашгүй гэнэ лээ. Үнэтэй машин тэргийг баруун солгойгүй сольж унадаг, баян айлын эрх хүү л лав биш. Харин тэрбээр ОХУ-ын Ерөнхийлөгч шиг нэр нөлөөтэй, зангарагтай объектод мөрөөддөг байж мэднэ. Түүнд ОХУ-ын ерөнхийлөгч В.Путныг дуурайж, цээж нүцгэн, буюу бариад зогсож буй гэрэл зураг бий. Мөн морь унасан, нохой эрхлүүж буй зургууд нь ч тун адилхан “поз”-той байдаг. Тиймээс түүнийг В.Путин стилийг гэгцгээдэг. Хүрэлсүх бас шүтэн бишрэгч шигээ хэвтээ байдлаас 150 кг шахдаг шатгүй тамирчин.

### “Эхнэртээ амаргүй хань, охиддоо муу аав”

Энэ бол түүний өөртөө өгсөн үнэлгээ. Шадар сайд намтраа ам бүл дөрөв гэж бичсэн байна лээ. Хоёр охинтойг нь монголчууд бүгдээрээ шахам дуулсан байлгүй. Том охин нь МУИС-на дүүргэсэн байх учиртай. Түүнийг өвөө болсон гэж дуулаагүй. Болбол ч хэвлэлийнхэн шуугих нь дамжиггүй. Тэрбээр Цэргийн нэгдсэн дээд сургуулийн оюутан байхдаа гэргий Болорцэгтэйгээ танилцжээ. Гэхдээ угсаар. Энэ тухайгаа “Би тэгэхэд цэргийн сургуулийн гуравдугаар курсийн сонсогч байлаа. Нэг удаа жижүүрээ буугаад амарч хэвтээ манай курсийн хэдэн нөхөр нэгдүгээр курсийн нэг оюутныг дундаа суулгачихаад “Танай ангийн хамгийн хөөрхөн охин хэн бэ” хэмээн байцааж байгаа сонстов. Би сонсоод л хэвтээд байгаа юм чинь. “Манай ангийн хамгийн хөөрхөн нь Цэндсүрэн, Болорцэг хоёр” л гэнэ. Болорцэг гэдэг нэрийг нь тогтоогоод авлаа. “Утасны дугаарыг нь мэдэх үү” гэсэн нөгөө нөхөр “322234” гэж байна. Тогтооход их амархан

дугаар. Тэгээд сарын дараа жижүүрт гарахдаа шөнийн 23:00 цагт өнөө дугаар руу угасдлаа даа. Нэг охин утас авсан. “Сайн байна уу. Намайг Хүрэлсүх гэдэг. Өөртэй чинь танилцъя” гэсэн чинь “Танихгүй хүнтэй ярихгүй” л гэж байна. Хамгийн анх бидний хооронд ийм яриа өрнөсөн. Түүнээс хойш угсаар ярьсаар байгаад дөрөв, таван сарын дараа зуны амралтаараа анх удаа болж, уулзсан юм. Одоо энэ Их дэлгүүрийн баруун хойно “Мандухай” зочид буудлын үүдэнд уулзаж билээ. Тэр үед бороо ороод сайхан байсан шүү. Бяцхан наргиа хийхэд, хөөрхөн Болороо маань 322234 утсан дээрээ байгаа больсоор удаж байгаа шүү” хэмээн хуучилж байсан юмдаг.

### Шадар сайд У.Хүрэлсүхийн намтар:

- Төрсөн он: 1968
- Төрсөн газар: Улаанбаатар хот
- Ам бүл 4, эхнэр 2 охины хамт амьдардаг.
- Боловсрол: 1985 онд нийслэлийн 10 жилийн хоёрдугаар дунд сургуулийг, 1989 онд Батлан Хамгаалахын Их Сургуулийг Улс төр судлаач мэргэжлээр, 1994 онд Төрийн Захиргаа, Удирдлагын Хөгжлийн Институтыг Төрийн удирдлагын арга зүйч мэргэжлээр, 2000 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Дээд Сургуулийг Эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн.
- Ажлын туршлага:
  - 1989-1990 онд Монголын Ардын Армийн 152 дугаар ангид улс төрийн орлогч
  - 1991-1994 онд МАХН-ын Төв хороонд улс төрийн ажилтан
  - 1994-1996 онд Улсын Их Хурал дахь МАХН-ын Бүлгийн Ажлын албанд зөвлөх
  - 1996-1997 онд МАХН-ын Залуучууд Хөгжил төвийн Ерөнхий захирал
  - 1997-1999 онд Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбооны Ерөнхийлөгч
  - 1999-2000 онд Улсын Их Хурал дахь МАХН-ын Бүлгийн Ажлын албанд Нийгмийн бодлогын зөвлөх
  - 2000-2005 онд Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбооны Ерөнхийлөгч
  - 2000-2007 онд МАХН-ын Удирдах Зөвлөлийн гишүүн
  - 2000-2004 онд Улсын Их Хурлын гишүүн
  - 2004-2008 онд Улсын Их Хурлын гишүүн
  - 2004-2006 онд Засгийн Газрын гишүүн, Онцгой Байдлын Асуудал Эрхэлсэн Монгол Улсын Сайд
  - 2006-2008 онд Засгийн Газрын гишүүн, Мэргэжлийн Хяналтын Асуудал Эрхэлсэн Монгол Улсын Сайд
  - 2007 оноос Монголын Зүүний хүчний холбооны ерөнхийлөгч
  - 2008-2012 МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга
  - 2012 оноос Улсын Их Хурлын гишүүн
  - Мөн Улс төрийн шинжлэх ухааны магистр, Бэлтгэл хурандаа.

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# СУГАЛААНД ОДГУЙ



## ХОЁР НА

Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Арга ядсан эцэг,  
эхчүүд өөрсөддөө  
дугаар тараажээ

“Одоохэддэхүүннь орж байна вэ”, “Хоёр настай хүүхдийн бүртгэл юу болж байна”, “Дэс дараалаараа орно шүү”, “Юун хүн орох гээд байна. Бид дөрөв, тав хоног ирж, дугаарласан” гэх уур бухимдалтай, нэг нэгнээсээ өрсөж орох гэсэн эцэг, эхчүүдийн тулаан аль хэдийнэ эхэлжээ. Энэ нь цэцэрлэгийн бүртгэл эхэлснийг гэрчлэх аж. Бидний очсон эхний цэцэрлэг бол Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэг. Тус цэцэрлэгийг тойруулан цэнхэр хашаа татсан байх бөгөөд хаалганы урд хэсэгт хүүхдээ цэцэрлэгт бүртгүүлэх гэсэн эцэг, эхчүүд “шавжээ”. Ар талд зогсож байгаа хүмүүст урд чухам юу болж, ямар зохион байгуулалттайгаар бүртгэл явагдаж байгаа нь бараг мэдэгдэхгүй шахам учраас эцэг, эхчүүд бие биесээ ам асуун, дам сураг сонсож байв. Цэнхэр хашааны хаалгыг таглан 40 гаруй насны хоёр эрэгтэй зогсож харагдав. Тэд эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж, урт дараалал үүсгэсэн хүмүүсийг тав, таваар нь оруулах чухал үүрэг хүлээсэн “жагсаалын дарга нар”. Цэцэрлэгийн бүртгэл эхлэхээс хэд хоногийн өмнө өөрийн хүүхдийн хүмүүжих цэцэрлэгт өдөр бүр ирсээр зарим эцэг, эх нэг нэгийг андахаа больж, нэгдсэн зохион байгуулалтад орохоор ярьж тохиролцон өөрөө өөрсөддөө хүртэл дугаар тараажээ. Авсан дугаарынхаа дагуу хүүхдээ бүртгүүлчихээд гарч ирж буй Б.Нансал гэх эмэгтэйтэй бид таарав. Тэрбээр “Би өнгөрсөн долоо хоногийн дөрөв дэх өдрөөс хойш хүүхдийнхээ бүртгэлийн асуудлыг хөөцөлдсөн. Учир нь жил бүр мэдээгээр цэцэрлэгийн бүртгэлийн тухай гардаг. Маш эмх замбараагүй харагдаж л даа. Энэ талаархи мэдээллийг өмнө нь хангалттай авсан учраас эртнээс цэцэрлэг дээр нь ирсэн юм. Тэр нь ч оносон. Намайг ирэх үед нэлээд хэдэн

эцэг, эхчүүд байсан. Би өдөр бүр ирсэн. Тэгсний үр дүнд тараасан дугаарыг авч чадсан. Би 33 дугаартай. Сая орчихоод гарч ирлээ. Хүүхдээ ямар ч байсан бүртгүүлчихлээ. Олон хоног явсаны хэрэг бүтлээ. Хэрвээ манай хүү цэцэрлэгт орохгүй бол харах хүн байхгүй. Бид бүгд ажилтай. Хувийн цэцэрлэгт явуулья гэхээр мөнгө, санхүүгийн хувьд хүндрэлтэй байдаг. Ямар ч байсан хүүхдээ цэцэрлэгтэй болгочихлоо. Нэгдсэн зохион байгуулалтад орсон нь зөв гэж бодож байна. Энд байгаа хүн бүр л хүүхдээ цэцэрлэгт оруулья гэсэн нэг зорилготой,

хэмээн сандарсан аятай угтлаа. Тэд эцэг, эхийн төлөөлөл буюу нэгдсэн зохион байгуулалтын удирдагчид. Тэдний дунд эцэг, эхийн зөвлөлийн дарга Б.Нарангэрэл гэх 40 орчим насны эмэгтэй байсан учраас түүнтэй цөөн хором ярилцлаа.

Б.Нарангэрэл:  
19-нөөс хойш  
таван хүн гурван  
цагийн зайтай  
жижүүрт гарсан

-Эцэг, эхчүүд нэгдсэн  
зохион байгуулалтад орж

...Шинэ хүүхдүүдээ 22-23-нд,  
хуучин хүүхдүүдээ 24, 25-нд  
бүртгэнэ. Гадаа байгаа эцэг,  
эхчүүд өөрсдөө дугаар тараасан.  
Манай цэцэрлэгээс ямар ч  
дугаар тараагаагүй” гэсэн юм.  
Тус цэцэрлэгт хамран сургах  
тойргийн дагуу Сүхбаатар  
дүүргийн 10-12 дугаар хорооны  
хүүхдүүд бүртгүүлэх ёстой  
ажээ...

нэг зовлонтой. Тиймээс бид энэ асуудлаа өөрсдөө л шийдэхгүй бол хэн шийдэх вэ дээ. Нэгэнт төрөөс огч байгаа тоо нь энэ юм чинь” хэмээн учирласан юм. Сүхбаатар дүүргийн 234 дүгээр цэцэрлэгийн байр хашаанаасаа 20 метр орчим зайтай юм. 20 метрийн цаана цэцэрлэгийн гадна талд тав, зургаан эцэг, эх зогсч харагдав. Манай сурвалжлах хэсэг ч ирсэн учраа хэлж, цэцэрлэг рүү орох гэсэн боловч дараалалд зогсох хүмүүс урдуур дайрах нь хэмээн бухимдах нь тэр. Арга ч үгүй биз. Авах хүүхдийн тоо хязгаартай, орохыг хүссэн хүүхдийн тоо их шүү дээ. Учир явдлаа нэлээд тайлбарласны эцэст эцэг, эхчүүд сая нэг юм ойлгож, орох зөвшөөрөл олгов. Арайхийн өнөөх цэнхэр хаалгаар орж, цэцэрлэг рүү дөхөж очвол гадна нь зогсоо эцэг, эхчүүд “Орох болоогүй ээ. Дугаар чинь болсон юм уу”

дугаар тараасан гэлээ. Хэдэн цагт тараасан бэ?

-Цэцэрлэгийн бүртгэл жил бүр ачаалалтай болдог. Тиймээс бид ачааллыг бууруулах, бүртгэлийн үйл ажиллагааг эмх, цэгцтэй зохион байгуулахын тулд нэгдсэн зохион байгуулалтад орсон. Өглөөний 06:00 цагт дугаар тараасан. 10:00 цагийн байдлаар 45 дахь хүн бүртгүүлсэн байна.

-Нийт хэчнээн дугаар тараасан бэ?

-120 дугаар тараасан. Дугаар бүр дээр хүүхдийнх нь нэрийг бичсэн байгаа.

-Дугаар тараахыг бүх эцэг, эх дэмжсэн үү. Өнөөдөр өглөө ирсэн хүмүүс байгаа байх. Тэр хүмүүс яах вэ?

-Бид эцэг, эхийн зөвлөл гэж байгуулсан. Үүний дараа яришдаг байгаад тав таваараа жижүүрт гарахаар болсон юм. Тэгээд өдөр бүр ирж, гурав гурван цагийн зайтай ирцээ

бүртгэхээр шийдсэн. Бүртгэл хийхдээ тодорхой зохион байгуулалт хийсэн. Тухайлбал, хэрвээ тухайн хүүхдийн ээж, аав гурван удаа цэцэрлэг дээр ирэхгүй тасалбал өөр цэцэрлэг хайсан байна гэж үзээд бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авсан. Гадаа зогсч байгаа дугаар авсан хүмүүс өдөр бүр ирж, ирцээ бүртгүүлсэн юм. Одоо ирж байгаа хүмүүсийг мэдэхгүй. Гэхдээ бид жил бүр орон даяар хүүхдийн цэцэрлэгийн асуудал хүнд хэцүү байгааг хэвлэл мэдээллээр дамжуулан авдаг. Фэйсбүүкээр ч гэсэн авч байгаа шүү дээ. Нэгдсэн зохион байгуулалтыг эцэг, эхчүүд өөрсдийн хүсэлтээр хийсэн. Ээж, аав нар өөрсдөө зохион байгуулж байгаа учраас ямар нэгэн асуудал байхгүй гэж бодож байна. Гэхдээ өөрсдөө олон өдөр ирэхгүй тасалчихаад дугаар аваагүй хүмүүс гадаа байна лээ.

...Бид ийн ярилцсаны дараа цэцэрлэгийн эрхлэгчтэй уулзсан юм. Биднийг тус цэцэрлэгт орох үед бүртгэлийн үйл ажиллагаа ид өрнөж байсан бөгөөд нэг цагдаагийн ажилтан, хоёр багш болон эцэг, эхийн төлөөлөл бүртгэлийн ажилд хяналт тавьж байлаа. Цэцэрлэгийн эрхлэгч

Ц.Дариймаагаас бүртгэлийн ажлын талаар асуухад “Нийслэлийн Боловсролын газраас өгсөн даалгаврын дагуу нийт 40 хүүхэд шинээр бүртгэж авна. Үүнээс хоёр настай 30 хүүхдийг л бүртгэнэ. Үлдсэн 10 хүүхдийн хоёр нь зорилготой бүлгийн хүүхэд байх юм. Тэдгээр хүүхдийг хорооныхоо нийгмийн ажилтантай хамтарч авна. Харин үлдсэн найм нь манай ажилчдын хүүхэд байх юм. Мөн таван настай 10 хүүхэд бүртгэнэ. Нийслэлийн Боловсролын газраас өгсөн даалгаврын дагуу л бүртгэлийн ажлыг хийж байна. Харин гурван настай таван хүүхэд авна. Шинэ хүүхдүүдээ 22-23-нд, хуучин хүүхдүүдээ 24, 25-нд бүртгэнэ. Гадаа байгаа эцэг, эхчүүд өөрсдөө дугаар тараасан. Манай цэцэрлэгээс ямар ч дугаар тараагаагүй” гэсэн юм. Тус цэцэрлэгт хамран сургах тойргийн дагуу Сүхбаатар дүүргийн 10-12 дугаар хорооны хүүхдүүд бүртгүүлэх ёстой ажээ. Нийслэлийн Боловсролын газраас ирсэн бүх хүүхдүүдийг бүртгэж, сугалаа явуулна гэж мэдээлсэн. Гэвч тус цэцэрлэг сугалаа явуулахгүй нь. Биднийг цэцэрлэгээс гарахад хашааны гадна талд хүүхдээ бүртгүүлэхээр ирсэн эцэг, эхчүүд нэмэгдсэн байлаа.

Тэдний дунд “Дугаар аваагүй. Одоо яах вэ” гэсэн хүмүүс ч байв. Хүүхдээ хөтөлсөн 23 орчим насны залуухан эмэгтэйг н.Сараа гэдэг. Тэр мөн адил дугаар аваагүй гэнэ. Тэрбээр, энэ тухайгаа “Цэцэрлэг дээр нь ирэхэд бүртгэл эхлэх болоогүй гэж байсан. Намайг ирэхэд ганц нэг ээж, аав нар харагдаж байсан. Тэгээд болоогүй учраас дахиж ирээгүй. Зурагтаар 22-нд нэгдсэн журмаар ирсэн хүүхэд болгоныг бүртгэнэ гэсэн мэдээлэл үзсэн. Тэгээд ирж байна. Одоо яах вэ” хэмээн яриу.

Хоног  
дугаарласан  
ч эмх,  
замбараагүй  
байдал үүсчээ

Бидний очсон дараагийн цэцэрлэг Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэг. Тус цэцэрлэгт бүртгэлийн үеэр эмх замбараагүй байдал үүсчээ. Биднийг очих үед цэцэрлэгийн хашааны гадна “Сугалаагаар хүүхэд бүртгэх нь шударга бус” хэмээн уурлаж, бухимдсан эцэг, эхчүүдийн цуваа үүссэн байлаа. Бид цэцэрлэгийн гадна нэлээд бухимдалтай зогсох нэгэн



## РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ-УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



### СУРГУУЛИЙН ДАВУУ ТАЛ:

1. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын төлбөргүй ( мэргэших зардлаас бусад ) төрийн өмчийн сургууль.
2. Техникийн боловсролтой төгсөгчид Их, дээд сургуулийн 2-3 курсаас эхлэн суралцах боломжтой.
3. Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар мэргэжлийн иж бүрэн лаборатори, сургалтын газраар бүрэн хангагдсан.
4. Сургууль нь 19000 гаруй номын фонд, 50 суудалтай уншлагын танхим бүхий номын сантай.
5. Орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжтэй, дадлагын газарт үйлдвэрийн дадлага хийх боломжтой.
6. Суралцагчид өөрийн сонирхсон чиглэлээр дугуйлан сэцэнд үнэ төлбөргүй хамрагдан суралцах боломжтой.
7. Оюутан солилцоогоор Солонгос, Энэтхэг болон бусад орнуудын ижил төрлийн сургуулиудтай танилцаж, аялах боломжтой.
8. Суралцагч өөрийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргах, бүтээлээ зах зээлд борлуулах боломжтой.

### ОЮУТАН СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

1. Хөдөө орон нутгийн суралцагсад дотуур байраар үнэ төлбөргүй хангагдана.
2. Амжилттай суралцагчдын мэргэшүүлэх зардлыг тодорхой хувиар хөнгөлнө.
3. Суралцагчид сар бүр 70000 төгрөгийн тэтгэлэг авна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй, хагас болон бүтэн өнчин суралцагчдын мэргэшүүлэх зардлыг 1 удаа 50-100% хөнгөлнө.
5. Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих эрх эдлэнэ.
6. Мэргэжлийн чиглэлээр олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцох боломжоор хангана.

### Элсэлтийн бүртгэл:

2016 оны 8 -р сарын 10-наас 26-ныг хүртэл  
(өдөр бүр 09<sup>00</sup>-18<sup>00</sup> цаг)

Дараах мэргэжлээр  
элсэлт авч байна

### ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ

№	Мэргэжил	Элсэлтийн боловсролын түвшин	Суралцах хугацаа	Мэргэжил олгох боловсролын баримт бичиг
1	Үйлдвэрийн график дизайн	Бүрэн дунд 12-р анги төгссөн	3 жил	Төрийн боловсролын диплом
2	Дизайнч хушцаны			
3	Авто машины механик			
4	Чимэглэх урлаг		1.5 жил	
5	Мехатроник			
6	Нягтлан бодогч, төлбөр тооцоо цалин хөлсний			
7	Теоологич, ус засах урлагийн			
8	Теоологич, гоо сайоны урлагийн			
9	Вэб мультимедиа			
10	Цохилтван техникч			
11	Техник холболт сулгач			

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

№	Мэргэжил	Элсэлтийн боловсролын түвшин	Суралцах хугацаа	Мэргэжил олгох боловсролын баримт бичиг
1	Усчин	Сүүр, 9-р анги төгссөн	2.5 жил	Мэргэжлийн болон бүрэн дунд боловсролын үнэмлэх
2	Ойвол бүтээгдэхүүний өдсгчин			
3	Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан			
4	Цахим харилцан үйлчилгээний ажилтан			
5	Цэцэрлэгийн			
6	Оператор/Логогийн свайтэй/			
7	Зочид буудал жуулчны баазын үйлчилгээний ажилтан			
8	Нэрийн бичгийн дэргэ аргын заргийн ажилтан			
9	Гагцурчин			
10	Хөвсгөлийн дизайнер			
11	Гоо засагч			
12	Авто машины засварчин			
13	Арсавар гар урлагийн зүйл урлагч			
14	Гар урлагийн зүйл урлагч			
15	Үнэг адалгийн дорхон			
16	Зураач, чимэглэгч			
17	Усчин			
18	Гоо засагч			
19	Ойвол бүтээгдэхүүний өдсгчин			
20	Авто машины засварчин			
21	Цэцэрлэгч, цэцэрлэгт хэрэглэлийн			
22	Савуу бүртгэл тооцооны туслах ажилтан			
23	Хөвсгөл үйлдвэрийн хөвсгөч			

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10-р хороо  
Утас/Факс: 99658848, 96563033, 89063459

Вэб хуудас: www.pas.mn  
И-мэйл: gandhi\_school@past.edu.mn



# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



## НАСТНУУД ДУУСООН ХОЦРОХ НЬ

эмэгтэйгэй уулзаж ярилцсан. Түүнийг Б.Эрдэнэцэцэг гэдэг бөгөөд наймдугаар сарын 12-ноос эхлэн цэцэрлэгийн бүртгэлийн талаар судалж эхэлжээ. Тэрбээр "Би хүүхдээ цэцэрлэгт бүртгүүлэхийн тулд энэ сарын 12-нд энд ирж, багш нартай нь уулзсан. Бүртгэл 22-нд эхэлнэ гэж хэлсэн. Би хувьдаа сугалаагаар бүртгэхийг дэмжихгүй байна. Жил бүр эцэг, эхчүүд хүүхдээ цэцэрлэгт бүртгүүлэхийн тулд заавал дугаарлаж, эсвэл сугалаа сугалах ёстой юу. Ийм байж болохгүй. Сугалаа шударга болно гэхэд би итгэхгүй байна. Тиймээс ч өчигдөр иржхоносон. Гэтэл өглөөнөөс эхлээд л эмх, замбараагүй байдал үүссэн. Ямар ч зохион байгуулалт байхгүй. Яах вэ, хүн бүр хүүхдээ улсын цэцэрлэгт оруулахыг хүсч байгаа. Ийм зүйл болно гэдгийг мэдсээр байж нэгдсэн зохион байгуулалтад оруулах хэрэгтэй шүү дээ. Улстөрчид юу хийдэг юм бэ. Цэцэрлэгийн асуудлыг нэн тэргүүнд шийдэх ёстой. Бидний татварын мөнгийг хэрэггүй зүйлд зарцуулж байгаад харамсч байна. Би хувьдаа сугалааг дэмжихгүй. Хоносон ч одоо болтол орж чадаагүй л байна" хэмээн бухимдав. Тус цэцэрлэг нийт 325 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд энэ жил нийт 270 хүүхэд бүртгэж авах гэнэ. Дээд хэмжээгээрээ ажиллаад 270 хүүхэд бүртгэж авч байгаа боловч тус цэцэрлэгийн хамран сургах тойрогт сургуулийн өмнөх боловсрол эзэмших шаардлагатай 610 хүүхэд байдаг байна. Ийнхүү цэцэрлэгийн хүртээмж, хүрэлцээ муу, мөн сугалаанд дургүйцсэн эцэг, эхчүүдийн дунд үймээн үүссэн ажээ. Энэ үеэр мөн цэцэрлэгийн эрхлэгч, биднийг доромжилсон, хандив гэж авлига авсан гэх яриа ч гарч байв. Бид тус цэцэрлэгийн эрхлэгчтэй уулзах гэсэн хэдний ч уурлаж, бухимдсан олны дунд дотогш орох боломж олдоогүй юм. Бүртгэл эхэлсэн анхны өдөр ердөө хоёр цэцэрлэгийн байдалтай танилцахад л ийм байв. Хүүхдээ улсын цэцэрлэгт үнэ төлбөргүй оруулчих юмсан гэсэн эцэг, эхчүүд өдөр шөнөгүй дараалал үүсгэж, бүр уурлаж бухимдаад ч амжилтад хүрэхгүй бололтой. Тиймээс бид цэцэрлэгийн бүртгэл эхэлсэн эхний өдрийн сурвалжлагаа үүгээр төгсгөсөн юм.

**Хоёр дахь өдрийн байдлаар 170 хүүхэд шинээр бүртгүүлжээ**

Цэцэрлэгийн бүртгэлийн хоёр дахь өдөр. Эхний өдөр ихэнх цэцэрлэгүүд ачаалалтай байсан болохоор ч тэр үү энэ өдөр зарим цэцэрлэгүүд хөл

хөдөлгөөн багатай харагдсан. Бидний очсон хэд хэдэн цэцэрлэгийн бага бүлгийн бүртгэл дуусч, дунд, ахлах, бэлтгэлбүлгийн бүртгэл эхэлсэн байв. Манай сурвалжлах хэсэг Чингэлтэй дүүргийн 124 дүгээр цэцэрлэгийг зорьсон юм. Бидний очих үед цэцэрлэгийн бүртгэлийн ажилчид цайндаа орсон учраас эцэг, эхчүүд байхгүй байв. Тиймээс тус цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэгтэй уулзаж, цэцэрлэгийн бүртгэлийн талаар ярилцлаа. Тэрбээр "Манай цэцэрлэгийн шинэ ангийн бүртгэл маш зохион байгуулалттай болсон. Бусад цэцэрлэг дээр болсон шиг эмх, замбараагүй байдал гараагүй. Манай цэцэрлэг нийт 500 гаруй хүүхдийн хүчин чадалтай. Чингэлтэй дүүргийн 10, 11 дүгээр хорооны нийт 600 хүүхэд хамрагдана. Ер нь бүртгэлийн ажил амжилттай үргэлжилж байна. Шинэ хүүхдүүдээ өнөөдөр бүртгээд дуусна. Одоогийн байдлаар 170 гаруй хүүхэд бүртгүүлсэн байна. Маргааш дунд бүлгийн бүртгэл эхэлнэ" хэмээсэн. Тус цэцэрлэг энэ жил нийт 280 хүүхэд бүртгэх аж. Харин сугалааны хувьд бүртгүүлсэн хүүхдийн тоо хэтэрсэн тохиолдолд явуулах гэнэ. Өөрөөр хэлбэл, 280-аас дээш хүүхэд бүртгүүлбэл сугалаа явуулах юм байна. Бид тус цэцэрлэгээс гарч, Баянгол дүүргийн 86, 161 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч нартай уулзсан. Тус цэцэрлэгүүдийн бүртгэл мөн үргэлжилж байна билээ.

**Л.Олонцэцэг: Гурван настай 21 хүүхдийг бүртгэнэ**

*/Баянгол дүүрэг 161 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч/*

**-Нийг хэчнээн хүүхэд бүртгэх вэ. Бүртгэлийн явц хэр байна вэ?**

-Энэ хичээлийн жилд бага бүлэгт 108 хүүхэд бүртгэнэ. Харин дунд болон ахлах бүлэгт тус бүр 21 хүүхэд бүртгэхээр болсон. Өнөөдрийн байдлаар шинээр 20 хүүхэд бүртгүүлсэн байна.

**-Гурван настай хүүхдийн нэмэлт бүртгэл авч байна уу. Зарим цэцэрлэг гурван настай хүүхэд бүртгэхгүй гэж байсан?**

-Манай цэцэрлэг дунд бүлгийн хүүхдийг бүртгэж байгаа. Энэ жил гурван настай 21 хүүхдийг нэмэлтээр бүртгэнэ. Хэрэв гурван настай хүүхдүүд бидний бүртгэх хэмжээнээс хэтэрвэл нэрсийг сугална.

**-Өөр дүүргийн иргэд хүүхдүүдээ бүртгүүлэхээр ирж байна уу?**

-Тийм. Хэд хэдэн хүн өргөдөл гаргасан. Манай харьяа биш

**...Харин наймдугаар сарын 26-нд нэгдсэн журмаар нийт хүүхдүүдийн дунд сугалаа явуулахаар болсон билээ. Гэсэн ч бодит байдал дээр сугалаа явуулахгүй гэсэн цэцэрлэг, сугалааг эсэргүүцсэн эцэг, эхчүүд ч байсныг нуух юун...**



ч манай цэцэрлэгтэй ойрхон байрлалтай айлууд бий. Тийм эцэг, эхчүүд ирж байна. Мөн өрх толгойлсон хүмүүс хүүхдээ бүртгүүлэхээр ирлээ. Түүнчлэн нийслэлийн Боловсролын газраас өгсөн даалгаврын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүртгэж байгаа.

**-Тэдгээр өргөдлүүдийг яаж шийдвэрлэж байна. Заавал**

**харьяа дүүрэгтээ бүртгүүлэх ёстой байдаг шүү дээ?**

-Уг нь бол харьяа дүүрэгтээ л хандах ёстой байдаг. Гэхдээ бид таван настай хүүхдийг бүртгэсэн. Таван настай хүүхдүүд харьцангуй бага бүртгүүлдэг учраас орон тоо гарах тохиолдол бий. Мөн Боловсролын газраас ч гэсэн таван настай хүүхдийг бүгдийг нь бүртгэх даалгавар өгсөн.

**Ц.Мөнхтуул: Сугалаа явуулахгүй**

*/Баянгол дүүргийн 86 дугаар цэцэрлэгийн эрхлэгч/*

**-Бүртгэлийн ажил хэр явагдаж байна вэ. Эцэг, эхчүүд гадаа дугаарласан**



**хүүхдүүдийн нэрийг сугалах уу?**

-Сугалаа сугалахгүй. Учир нь 115 хүүхэд хангалттай хамрагдчихна. Ойрхон олон цэцэрлэг байдаг учраас илүү хүүхэд бүртгүүлэхгүй байх.

**-Гурван настай хүүхдүүдийн нэмэлт бүртгэл авч байгаа юу?**

-Авч байгаа. Өнгөрсөн жил бага бүлэгтээ цөөхөн хүүхэд авсан. Тиймээс энэ жил бэлтгэл бүлэгтээ хүүхэд нэмж авах боломжтой байгаа юм.

**-Өнгөрсөн жил хэчнээн хүүхэд хамрагдсан бэ?**

-Өнгөрсөн хичээлийн жилд бага бүлэгтээ нийт 140 гаруй хүүхэд авч байсан. Харин энэ жил 115 хүүхэд авна. Энэ жил бага бүлэгт 115 хүүхэд авах юм бол дараа жил бэлтгэл бүлэгтээ 115 хүүхэд дээрээ нэмж хүүхэд

наймдугаар сарын 22-25-нд бүртгэлийн ажлыг зохион байгуулна. Ингэхдээ хүүхэд бүрт "Элсэлтийн тасалбар" олгох юм. Харин наймдугаар сарын 26-нд нэгдсэн журмаар нийт хүүхдүүдийн дунд сугалаа явуулахаар болсон билээ. Гэсэн ч бодит байдал дээр сугалаа явуулахгүй гэсэн цэцэрлэг, сугалааг эсэргүүцсэн эцэг, эхчүүд ч байсныг нуух юм. Өнгөрсөн хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 233, төрийн бус өмчийн 399 цэцэрлэгт нийт 91687 хүүхэд хамрагдсан талаар Нийслэлийн Боловсролын газраас мэдээлсэн. Үүнээс 69428 буюу 75.7 хувь нь төрийн өмчийн, 22259 буюу 24.3 хувь нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдсан байна. Харин 2016-2017 оны хичээлийн

бүртгээд 140 гаруй хүүхэд авах боломжтой болох юм. Тийм учраас энэ жил гурван настай хүүхдүүдээ нэмэлт бүртгэл авч байгаа юм.

**-Танай цэцэрлэг засвартай байгаа юм байна. Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө засвар дуусах уу?**

-Хичээлийн шинэ жилээс өмнө дуусч амжихгүй. Тэгэхээр хичээлээ аравдугаар сарын 01-ээс эхэлнэ. Болж өгвөл аравдугаар сараас өмнө засвараа дуусгах гээд ажилчид маань амралтгүй л ажиллаж байна.

**Цэцэрлэгт хамрагдах ёстой хоёр настнууд 19 мянга хол давжээ**

Нийслэлийн Боловсролын газраас энэ жил цэцэрлэгийн бүртгэлийг сугалаагаар явуулах тухай мэдэгдсэн. Тодруулбал,

жилд 31 цэцэрлэгийн шинэ болон өргөтгөлийн барилга ашиглалтад орж, орны тоо 3990-ээр нэмэгдсэн аж. Харин төрийн бус өмчийн 44 цэцэрлэгт 2225-аас буюу 6115 хүүхдээр нэмэгдэж байгаа юм. Гэтэл энэ жил цэцэрлэгт хамрагдах ёстой 19 мянган хоёр настнууд бий гэсэн судалгаа бий.

Тэгвэл энэ жил шинээр ашиглалтад орсонтойгоо нийлээд 264 улсын цэцэрлэг үйл ажиллагаа явуулах нь. Хүүхдийнхээ гэрчилгээ, цээж зураг гээд бүрдүүлэх материалыг барьсан эцэг, эхчүүд энэ хэдэн цэцэрлэгийн хаяаг сахиж өнгөрөөх нь. Хэн нэгнийх нь хүүхдийн нэр сугалаанд таарвал тэр жилдээ баярлаад баршгүй азтай учирсан гэж болно гэхэд хилсдэхгүй биз. Харин сугалаанд нэр нь таараагүй, улсын цэцэрлэгт бүртгүүлж чадаагүй хоёр настнууд, хэзээ ч улсын цэцэрлэгийн үйлчилгээ авч байгаагүй гурван настнуудын эгнээнд шилжих бололтой.

# ДЭЛХИЙ

Улаанбаатарт:

**Маргааш**  
 Өдөр +17  
 Шөнө +4

**Нөгөөдөр**  
 Өдөр +19  
 Шөнө +6



**Аргын тооллын:**  
2016 оны 08-р сарын 24, Лхагва гараг

**Билгийн тооллын:**  
Налрын тэргүүн улаан бичин сарын шинийн 22. Таван шар лэнгэтэй Шар бар өдөр. Буд гараг

**Наран ургах/шингэх:**  
07:02 / 20:49

**Үс засуулбал:**  
Идээ ундаа элбэг олдono.



Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сүм дуганыг сэргээх, амьлуулах, өглөгийн түлдэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Гөлөг тэжээх, зөлийг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.



## НИКОЛАС САРКОЗИ ДАХИН ФРАНЦЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОХ УУ

сүүлийн хэдэн долоо хоногт мусальман шашинтнууд, цагаачдын тоог хумих талаар үг дуугарч эхэлсэн нь эсрэгээрээ А.Жюппегийн дэмжигчдийн тоо буурахад нөлөөлжээ. Хэрэв Саркози Бүгд найрамдах намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшвэл, улиран сонгогдох хүсэлтэй өнөөгийн тэргүүн Франсуа Олландтай хоёр дахь удаагаа өрсөлдөнө. Улмаар Олланд Саркозид ялагдвал Францын хамгийн нэр хүндгүй Ерөнхийлөгч болох юм. Гэхдээ хамгийн сүүлд явуулсан санал асуулгаас тэдгээр нэр дэвшигчдийн аль нь ч сонгогдохгүй байх магадлал өндөр байна. Урьдчилсан санал асуулсын дүнгээр Социалист намын тэргүүн хоёр дахь удаагаа сонгогдож чадахааргүй дүр зураг ажиглагдаж байгаа юм. Дэмжигчдийнхээ тоогоор Франсуа Олланд хэт барууны удирдагч Марин Ле Пен, төвч барууны хүчнээс нэр дэвшигч ноён Саркози юм уу, Ален Жюппегийн ард бичигдэж байна. Ямартай ч, Олланд дахин нэр дэвших эсэхээ ирэх арванхоёрдугаар сард зарлаж магадгүй нь.

### Б.ДАВАА

Францын Ерөнхийлөгч Франсуа Олландын бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбоотойгоор ирэх жил тус улсад Ерөнхийлөгчийн сонгууль болно. Тэгвэл энэ сонгуульд 61 настай экс Ерөнхийлөгч Николас Саркози өрсөлдөнө гэдгээ мэдэгджээ. Гэхдээ тэрбээр өөрийн тэргүүлэх төв барууны үзэлд Бүгд найрамдах намаас нэр дэвших эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Догшин хэрцгий хуучинсаг

үзэлтэй гэдгээрээ танигддаг Саркози өмнө нь тусулыг таван жилийн хугацаанд тэргүүлж байсан ч, дэмжигчдийнх нь хувь огцом унасны улмаас улиран сонгогдож чадалгүй суудлаасаа буусан. Гэвч террорист халдлага удаа дараа болсонтой холбоотойгоор нэр хүнд нь унаж буй Франсуа Олландыг залгамжлахаар дахин Ерөнхийлөгчид хүч үзэхээр шийдсэн аж. Түүний хувьд өчигдөр намын даргын албан тушаалаасаа бууж, Ерөнхийлөгчид Бүгд найрамдах

намаас нэр дэвшихээр өрсөлдөх болжээ. Намын нэр дэвшигчдээ тодруулах урьдчилсан шатны хурал ирэх арваннэгдүгээр сарын 20, 27-ны өдрүүдэд болох юм. Харин түүнээс урьтаж Саркози ирэх пүрэв гарагт буюу энэ сарын 25-нд Авиньон хотын Шаторена сүмд сонгуулийн кампанит ажлаа албан ёсоор эхлүүлж, уулзалт ярилцлага хийхээр болжээ. Николас Саркози 2012 онд сонгуульд дахин нэрээ дэвшүүлэхээр зүтгэсэн ч бүтэлгүйтэж байв. Хэт консерватив үзэлт

экс Ерөнхийлөгч өөрийн намынхнаасаа ч шүүмжлэл сонсох болсон. Николас Саркози сонгуульд нэр дэвшинэ гэдгээ илэрхийлснээр Францын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн тоо 13 болов. Түүний хамгийн том өрсөлдөгч нь Ален Жюппе. Бүгд найрамдахчууд түүнд хамгийн их итгэл хүлээлгэж болзошгүй байгааг ажиглагчид онцолж байна. Гэхдээ өнгөрсөн сарын 14-нд Ниццад гарсан автомашины осолтой холбоотойгоор Н.Саркози

### “Эль Чапо”-ын хүүг суллажээ

Мексикийн “хар тамхины хаан” гэгддэг “Эль Чапо” хочит Хоакин Гузманы хүү өнгөрсөн долоо хоногт Мексикийн Пуэрто Вальярта хотын нэгэн ресторанаас таван хүний хамт хулгайлагдсан билээ. Түүний хүүг Есүс Альфред Гузман гэдэг бөгөөд эдүгээ 29 настай Эль Чапогийн анхны эхнэрээс нь төрсөн юм. Тэгвэл саяхан хүү нь суллагдсан тухай “Си Эн Эн” мэдээлсэн байна.

Мексикийн Засгийн газрын нэрээ нууцалсан албаны эх сурвалж ч уг мэдээллийг баталжээ. Одоогоор Есүс Альфред Синалоа мужид байгаа гэнэ. Хэргийг эргэн сануулбал, энэ сарын 15-нд ресторан руу зөвсөгтэй этгээдүүд халдаж, зургаан хүнийг барьцаалсан байдаг. Тэдний дунд Хоакин Гузманы анхны эхнэрээс төрсөн хоёр хүүгийн нэг болох Есүс Альфред багтаж байв.

### Рок дуучин Хиллари, Трамп нартай өрсөлдөнө

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нар нэр дэвшиж буй. Тэдний хувьд жил тойрон сонгуулийн кампанит ажлаа үргэлжлүүлж, дэмжигчдийнхээ тоог өсгөхөд анхаарлаа хандуулж байгаа юм. Тэгвэл тэдэнтэй рок дуучин хүч үзэх гэнэ. Тэр бол эдүгээ 68 настай рок дуучин Элис Купер. Тэрбээр өөрийн цахим хуудсаараа дамжуулан энэ талаар мэдэгдсэн байна. Сүүлийн хэдэн жилийн турш хөгжмийн ертөнц дэх карьераа өсгөж, шүтэн бишрэгчдийнхээ хүрээллийг бэхжүүлсэн гэж хэлж болох Куперын мөрийн хөтөлбөр тун энгийн гэнэ. Тодруулбал, Саут Дакота мужийн Рашморе уул дээр төвтэсэн АНУ-ын түүхэн дэх дөрвөн ерөнхийлөгчийн асар том хөргийн хажууд өнгөрсөн жил нас барсан Их Британийн рок хамтлаг “Моторхид”-ын ахлагч “Лемми”-гийн хөргийг

байрлуулах, мөн эрт үеийн аугаа жүжигчдийн нэг Граучо Марксын зургийг 50 ам.долларын мөнгөн дөвсгэрт дээр хэвлэх гэх мэт заалтыг тусгажээ. Элис өмнө нь британичууд Европын холбооноос гарах сонголтыг хийх үед инээдмийн жүжигчин Петер Селлерс агсны хөргийг 20 фунт стирленгийн дөвсгэрт хэвлэхийг шаардаж байв. Ямартай ч энэ удаа АНУ-ын Ерөнхийлөгч болохоор шийдсэн рок дуучин сонгуулийн кампанитд ажилдаа зориулж, өөрийн 1972 онд дуулж хит болсон “Elected” дууныхаа шинэчлэн хувилбарыг дахин гаргахаар болсон гэнэ. Энэ дуу хит болох тухайн үед АНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль мөн болж байсан бөгөөд Ричард Никсон улиран сонгогдож байжээ. Элис Купер сонгуульд ялах магадлал тун бага. Гэхдээ хөгжмийн ертөнцөөс сонгуульд нэр дэвшинэ гэдгээ илэрхийлсэн ганц хүн Элис биш. Өмнө нь рэппер Канье Уэст 2020 оны ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөнө гэдгээ мэдэгдсэн билээ.

### “Азийн хамгийн хөгшин эмэгтэй” таалал төгсчээ



“Азийн хамгийн хөгшин эмэгтэй” гэж нэрлэгддэг 19 настай филиппин охин таалал төгсчээ. Ана Рошель Пондарегийн бие жирийн хүнтэй харьцуулахад 10 дахин хурдан хөгширдөг дөрвөн саяд нэг тохиох “Хатчинсон-Гилфорд” гэх өвчнөөр шаналж байсан бөгөөд түүний гадаад төрхнөөс нь үүдэн “Азийн хамгийн хөгшин эмэгтэй” хэмээн нэрлэж байжээ. Түүнийг амьд байх үед эмч нар нүүр болон биед нь үүссэн үрчлээг харж биологийн нас нь 136 гэх дүгнэлт гаргаж байсан юм. Түүний мөрөөдөл хайртай дуучин, жүжигчин Сара Джеринотой уулзах байсан. Тэрбээр мөрөөдлөө биелүүлж, 18 насны төрсөн өдрөөрөө түүнтэй уулзаж байжээ. Пьер Р.Клеро эмч түүний хөгшрөлтийг удаашруулахын тулд тусгай хоолны дэглэм гаргаж, зөвхөн түүнд зориулсан тос бүтээж байсан гэдэг. Анаг найман настай байхад аав нь архинд донтож түүнийг ээжтэй нь хамт орхижээ. Түүнд сургуульд явах таалагддаг байсан ч ээж нь сургалтын төлбөрийг нь төлж чадаагүйгээс үргэлжлүүлэн суралцаж чадаагүй юм. Тэрбээр ээждээ тусалж гудамжинд хувцас, жимс зардаг байсан ажээ.

## ТЭНГИС

КИНО ТЕАТР

2016-08-12

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.

Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиглагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онцноцтой гэмт хэрэгтнүүдэд оршоол үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.